



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 1/36

Улаанбаатар хот

┌ Түр заавар шинэчлэн батлах тухай ┐

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.3, 8.1.5, 8.1.13 дахь заалт, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.23 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, сэргийлэлтийн түр зааврыг нэгдүгээр, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хариу арга хэмжээний түр зааврыг хоёрдугаар, Эрүүл мэндийн байгууллагад тандалт хийх түр зааврыг гуравдугаар, Хаалттай орчин (Асрамжийн газар, цэргийн анги, хорих анги, уул, уурхайн кэмп, үйлдвэр)-д тандалт хийх түр зааврыг дөрөвдүгээр, Кластер (багц) өвчлөлийн судалгаа хийх түр зааврыг тавдугаар, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд мөрдөх халдварын сэргийлэлт, хяналтын түр зааврыг зургаадугаар, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын лабораторийн оношилгооны түр зааврыг долоодугаар, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед халдваргүйжүүлэлт хийх түр зааврыг наймдугаар, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын тархвар судалгааны хуудсыг есдүгээр, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын хавьтлын ажиглалтын хуудсыг аравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, голомтын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/, Зоонозын өвчин судлалын үндэсний төв /Н.Цогбадрах/, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв /Л.Насанцэнгэл/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

141220125

3. Мэргэжил аргагүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /Ж.Нарангэрэл/, Эрүүл мэндийн яамны дэргэдэх холбогдох мэргэжлийн салбар зөвлөл, эмнэлзүйн зөвлөх багт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/456, А/547, А/815 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАНДАЛТ, СЭРГИЙЛЭЛТИЙН ТҮР ЗААВАР

Нэг. Үндэслэл

Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр "Олон улсын шинж чанартай нийгмийн эрүүл мэндийн онц байдал", 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр "Цар тахал" болсныг зарласан.

ДЭМБ-ын SARS-CoV-2 вирусийн хувьслыг судлах Зөвлөх хорооны шийдвэрээр "онцгой анхаарал татах хувилбар"-ын вирусийн ангилалд Альфа, Бета, Гамма, Дельта хувилбарын вирус хамаарч байна.

2021 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр ДЭМБ-аас Өмнөд Африкаас илрүүлсэн B.1.1.529 хувилбарыг онцгой анхаарал татах "Омикрон" хувилбарын вирус хэмээн нэрлэсэн бөгөөд одоо дэлхийн 149 улс орон, нутаг дэвсгэрт бүртгэгдээд байна.

Манай улсад 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр Коронавируст халдвар (КОВИД-19)-ын анхны зөөвөрлөгдсөн тохиолдол, 11 дүгээр сарын 11-ний өдөр дотоодын халдвар бүртгэгдсэн анхны тохиолдлыг тус тус зарласан.

Одоогоор коронавируст халдвар (КОВИД-19)-ын 4 дэх удаагийн давалгаа эхэлж, вирусийн геномын бүрэн дарааллыг тодорхойлох шинжилгээ (Next-Generation Sequencing-NGS)-ээр тандалтын сорьцоос "Омикрон" хувилбарын вирус илэрч, халдварын тархалт "Улаан" түвшинд шилжээд байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх, сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг зохион байгуулахад энэхүү түр заавар, холбогдох дүрэм, журмыг баримтлан ажиллана.

Хоёр. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархвар судлал

2.1. Үүсгэгч

2.2.1. *Coronaviridae* овгийн Бета-коронавирусийн бүлгийн дан утаслаг РНХ агуулсан вирус.

2.2.2. Хүний коронавирусийг анх 1960-аад оны дунд үед нээсэн бөгөөд 4 дэд бүлэгт (альфа, бета, гамма, дельта) хуваадаг. Үүнээс 229E (альфа коронавирус), NL63 (альфа коронавирус), OC43 (бетакоронавирус), HKU1 (бетакоронавирус) хүнд өвчин үүсгэдэг. Бусад коронавирус нь амьсгалын замын халтай хам шинж (SARS), Ойрхи Дорнодын коронавируст халдвар (MERS), коронавируст халдвар (КОВИД-19)-ын шалтгаан болж байна.

2.2.3. Анхаарал татсан "Омикрон" хувилбар нь олон тооны мутацийг агуулсан бөгөөд гадаргуугийн "S" уургийн дараалалд дархлаанаас дайжих, халдварлах чадварыг нэмэгдүүлэхтэй холбоотой 26-32 мутаци үүссэн байна. Уг вирусийн халдварлах болон дархлаанаас дайжих чадварыг ДЭМБ болон гишүүн орнууд нарийвчлан судалж байна.

2.2. Халдварын эх уурхай

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлзүйн шинж тэмдэгтэй болон шинж тэмдэггүй хэлбэрээр өвчилсөн хүн.

2.3. Халдвар дамжих зам

2.3.1. Дуслын болон шууд хавьтал: Халдварт өртсөн хүний ярих, ханиах, найтаах, дуулахад амьсгалын замаас 5-10мкм хэмжээтэй вирус агуулсан дусал 1.5-2 метр хүртэлх зайд цацагдаж, эрүүл хүнд халдвар тараана. Үүнд:

- Халдварт өртсөн хүний биед хүрэлцэх эсхүл 1.5-2 метр хүртэлх зайд харьцах үед;
- Эрүүл мэндийн ажилтан хамгаалах хувцас, хэрэгсэлгүй эсхүл бүрэн бус хамгаалах хувцас хэрэгсэлтэйгээр шинжилгээ авах, зөөвөрлөх, асарч сувилах, үзлэг хийх, эмчлэх, тээвэрлэх үед;
- Өвчтөнд аэрозол үүсгэх ажилбар хийх, амьсгал, зүрх зогссон хүнд сэхээн амьдруулах тусламж, үйлчилгээ үзүүлэх үед;

Мөн агааржуулалт муутай, битүү орчин, өрөө тасалгаанд SARS-CoV-2 вирус агуулсан ≤ 5 мкм хэмжээтэй тоосонцор агаарын хөдөлгөөнөөр тархаж, халдварлуулах эрсдэлтэй.

2.3.2. Шууд бус хавьтал: Өвчтэй хүний хэрэглэж байгаа эд юмс, биологийн шингэн, цус, эмнэлгийн тусламж үзүүлэх үед ашигласан багаж, тоног төхөөрөмж зэргээр халдвар дамжина.

2.4. Нууц үеийн хугацаа

Нууц үеийн хугацаа 2-4 хоног, дунджаар 3 хоног байна.

2.5. Халдвартай үе

2.5.1. Эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс өмнөх 2 хоногт, эмнэлзүйн шинж тэмдэг илэрснээс хойш 2-3 хоногт халдвар тараах эрсдэл хамгийн өндөр, дархлаа дарангуйлагдсан өвчтөн 10-аас дээш хоногт халдвар тараах эрсдэлтэй.

2.5.2. Эмнэлзүйн шинж тэмдэггүй, лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан тохиолдлын халдвартай үеийг онош батлагдахаас өмнөх 2 хоног, батлагдсанаас хойш 5 хоногийн хугацаагаар тооцно.

2.6. Халдварт өртөх эрсдэлтэй хүн ам

Бүх хүн өртөх эрсдэлтэй. Бага насны хүүхдүүд, вакцины бүрэн тунд хамрагдаагүй хүмүүс, ялангуяа 60-аас дээш насныхан, амьсгал, зүрх судас, уушги, бөөр, элэг, цус, мэдрэлийн архаг өвчтэй, чихрийн шижинтэй, эрхтэн шилжүүлсэн, ДОХ ба бусад дархлаа дутмагшилтай, хорт хавдартай, таргалалт болон бусад суурь өвчтэй хүмүүс илүү өртөж, хүндрэх эрсдэлтэй.

2.7. Тохиолдлын тодорхойлолт¹

2.7.1. Сэжигтэй тохиолдол

А. Эмнэлзүйн шалгуур:

- Халуурах, ханиалгах ЭСХҮЛ;

¹ WHO COVID-19 Case definition

- Хуурай ханиалгах, хоолой хөндүүрлэх сэрвэгнэх, толгой өвдөх, хамар битүүрэх, нус гоожих зэрэг амьсгалын замын цочмог халдварын болон томуу, томуу төст шинж тэмдэг илэрсэн ЭСХҮЛ;
- Халуурах, ханиалгах, ядарч сульдах, толгой өвдөх, булчингаар өвдөх, хоолой өвдөх, хамар битүүрэх, шингэн нус гарах, амьсгалын дээд зам үрэвсэх, үнэр, амт мэдрэхүй алдагдах, амьсгаадах, хоолны дуршил буурах, дотор муухайрах, бөөлжих, суулгах, сэтгэл санаа тогтворгүй болох зэрэг 3 болон түүнээс дээш шинж тэмдэг илэрсэн;

Тархвар судлалын шалгуур

1. Эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс 14 хүртэлх хоногийн өмнө коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлзүйн шинж тэмдэгтэй хүнтэй хамт байсан ЭСХҮЛ
2. Эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс 14 хүртэлх хоногийн өмнө коронавируст халдвар (КОВИД-19) хүн амын дунд өргөн тархсан газарт амьдарч байсан, аялсан ЭСХҮЛ
3. Эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс өмнөх 14 хүртэлх хоногт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байсан/авсан;

Б. Тархвар судлалын холбогдолгүй боловч сүүлийн 10 хоногт өвчин эхэлж, 38°C-д болон түүнээс дээш халуурч, ханиалгасан, зайлшгүй эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх шаардлагатай амьсгалын замын цочмог хүнд халдвартай;

В. Тархвар судлалын хувьд холбогдолгүй, эмнэлзүйн шинж тэмдэг илрээгүй боловч SARS-CoV-2 антиген илрүүлэх түргэвчилсэн оношлуураар эерэг тодорхойлогдсон тохиолдол.

2.7.2. Магадлалтай тохиолдол

А. Дээрх эмнэлзүйн шинж тэмдгүүд илэрсэн, коронавируст халдвар (КОВИД-19)-ын магадгүй болон батлагдсан тохиолдолтой хавьтал болсон;

Б. Цээжний зурагт коронавируст халдвар (КОВИД-19)-ыг илтгэх өөрчлөлт бүхий сэжигтэй тохиолдол;

В. Бусад шалтгаангүйгээр үнэрлэх, амтлах мэдрэхүй алдагдсан тохиолдол;

Г. Шалтгаан тодорхойгүй амьсгалын дистресс хам шинжээр нас барсан тохиолдол.

Д. Шинжилгээнд S генийн бай илрэхгүй тохиолдлыг "Омикрон" хувилбараар өвчилсөн байж болзошгүй магадлалтай тохиолдол гэнэ.

2.7.3. Батлагдсан тохиолдол

А. Бодит хугацааны Полимеразийн гинжин урвал (бх-ПГУ)-ын шинжилгээгээр эерэг;

Б. Антигенд суурилсан түргэвчилсэн оношлуураар эерэг, магадлалтай тохиолдолтой хавьтал болсон, сэжигтэй тохиолдлын А эсхүл Б шалгуурт тохирсон хүн;

В. Антигенд суурилсан түргэвчилсэн оношлуураар эерэг, магадлалтай болон батлагдсан тохиолдолтой хавьтал болсон хүн;

Г. Сэжигтэй болон магадлалтай тохиолдлын эмнэлзүйн шалгуур үзүүлэлтэд тохирсон шинж тэмдэг бүхий хүн;

Д. Вирусийн бүтэн геномын дараалал тогтоох шинжилгээ эсхүл S ген тодорхойлох шинжилгээгээр SARS-CoV-2 вирусийн Омикрон хувилбар илэрсэн тохиолдол².

2.8. Хавьтлын тодорхойлолт

2.8.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй, магадлалтай болон батлагдсан тохиолдолтой эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс өмнөх 2 хоногт, шинж тэмдэг илэрсэнээс хойш 1-5 хоногийн хугацаанд хавьтал болсон ЭСХҮЛ:

2.8.2. Лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан эмнэлзүйн шинж тэмдэггүй хүнтэй онош батлагдахаас өмнөх 2 хоног, батлагдсанаас хойш 5 хоногийн хугацаанд хавьтал болсон хүнийг хэлнэ.

2.8.3. Дараах тохиолдолд хавьтал болсон гэж үзнэ.

2.8.3.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын магадлалтай болон батлагдсан хүнтэй 1.5-2 метрээс дотогш зайд 15 минут түүнээс дээш хугацаанд нүүр тулж харьцсан хүн;

2.8.3.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөнтэй хамт амьдардаг (нэг өрх, нийтийн болон дотуур байрны нэг өрөө, цэргийн хуаранд хамт амьдардаг, нэг гал тогооноос эсхүл нэг ширээнд хооллосон хүн, асрамжийн газар, хорих анги, ажлын өрөө);

2.8.3.3. Нийтийн тээврийн хэрэгсэл, галт тэрэгний нэг тасалгаа, нийтийн галт тэрэг, автобус, суудлын автомашинд суусан бүх зорчигч, нисэх онгоцны урд, хойд, хажуугийн 3 эгнээнд суусан зорчигч, үйлчилгээ үзүүлсэн ажилтан;

2.8.2.4. Хамгаалах хувцас, хэрэгсэлгүйгээр Коронавируст халдвар (КОВИД-19)-ын магадлалтай болон батлагдсан хүний биеийн аль нэг хэсэгт шууд хүрэлцсэн, тусламж үйлчилгээ үзүүлсэн, асарсан хүн;

2.8.2.5. Хамгаалах хувцас, хэрэгсэлгүйгээр Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөний биологийн шингэн, эд зүйлсэд шууд хүрэлцсэн хүн;

2.8.2.6. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлэх, сорьц авах үед хамгаалах хувцасны бүрэн бүтэн байдал алдагдсан, хувийн хамгаалах хувцас өмсөөгүй эрүүл мэндийн ажилтан.

2.9. Давтан халдвар

2.9.1. Өмнө нь бх-ПГУ шинжилгээ эсхүл антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээгээр батлагдсан, 90 ба түүнээс дээш хоногийн дараа бх-ПГУ-ын шинжилгээ эерэг (СТ утга 33-аас бага) эсхүл антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээгээр эерэг шинж тэмдэггүй болон шинж тэмдэг бүхий тохиолдол;

2.9.2. Өмнө нь бх-ПГУ шинжилгээ эсхүл антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээгээр батлагдсан, өмнөх халдвараас 45-89 хоногийн дараа эмнэлзүйн шинж тэмдэг дахин илэрсэн, бх-ПГУ-ын шинжилгээ эерэг (СТ утга 33-аас бага) эсхүл антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээгээр эерэг тохиолдол³.

² Enhancing readiness for Omicron (B.1.1.529), Technical brief and priority for Member States, WHO HQ, 23 December 2021

³ Investigate Criteria for Suspected cases of SARS-CoV-2, CDC

2.10. Геномын дарааллаар батлагдсан дахин халдвар

2.10.1. Тухайн хүнд эхний болон давтан халдварын үед цуглуулсан сорьцод вирусийн геномын бүрэн дараалал тогтоох шинжилгээгээр филогенетикийн хувьд ялгаатай үүсгэгч илэрсэн тохиолдлыг хэлнэ.

2.11. Тусгаарлалтын хугацаа

2.11.1. Батлагдсан тохиолдолд шинж тэмдэг илрээгүй бол 5 хоног гэрт, хөнгөн хэлбэрээр өвчилсөн бол 7 хоног гэрт, хүндэвтэр хэлбэрээр өвчилсөн бол 7 ба түүнээс дээш хоног эмнэлэгт, хүнд, маш хүнд хэлбэрээр өвчилсөн, дархлаа дарангуйлагдсан өвчтөнийг 10 ба түүнээс дээш хоног эмнэлэгт тусгаарлан эмчилнэ.

2.11.2. Хавьтлыг батлагдсан тохиолдолтой хамгийн сүүлд харьцсан өдрөөс хойш 5 хоног гэрт тусгаарлана.

Гурав. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын бэлэн байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

3.1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх, тандах, эрт илрүүлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээний журам, зааврыг боловсруулах, хэрэгжилтийг хангах;

3.1.2. Дэлхий дахинд SARS-CoV-2 вирусийн анхаарал татсан хувилбар шинээр мэдээлэгдсэн тохиолдолд хилийн нэвтрэх цэгийн тандалт хийх, гадаад улс орноос ирж байгаа иргэдийг тусгаарлан ажигл байранд тусгаарлах, шинжилгээний давтамжийн талаар тусгайлсан тушаал, шийдвэр гарган хэрэгжүүлэх;

3.1.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж, хэрэгжүүлэх;

3.1.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх, сэргийлэх арга хэмжээг нэгдсэн зохицуулалтаар хангах ажлын хэсэг, мэргэжлийн баг байгуулах;

3.1.5. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн бэлэн байдлын улсын хэмжээний нөөцийг үнэлэх, бүрдүүлэх, зохицуулах талаар Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;

3.1.6. Яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, оношлуур, урвалж, халдваргүйжүүлэх бодис, вакцины нөөцийн бэлэн байдлыг хангах;

3.1.7. Нэмэлтээр дайчлан ажиллуулах эрүүл мэндийн ажилтны судалгаа, сургалт хийхэд дэмжлэг үзүүлэх;

3.1.8. Резидент эмч, анагаахын чиглэлээр суралцаж буй төгсөх ангийн оюутан, сайн дурын ажилтны судалгааг гарган, дайчлан ажиллуулах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

3.1.9. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалт, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар УИХ, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Онцгой комисс, холбогдох бусад байгууллагыг мэдээллээр хангах;

3.1.10. ДЭМБ-аас 7 хоног бүр гаргадаг коронавирүсийн анхаарал татсан мутацлагдсан вирус бүртгэгдсэн улс орон, нутаг дэвсгэрийн жагсаалтыг тухай бүр гаргаж холбогдох байгууллагыг мэдээллээр хангах;

3.1.11. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаарх мэдээ, мэдээллээр хүн амыг хангах, эрсдэлийн мэдээлэл, харилцааг удирдан зохион байгуулах.

3.2. Халдварт өвчин судлалын үндэсний төв:

3.2.1. Олон улсын эрүүл мэндийн дүрмийн Үндэсний зохицуулагч байгууллагын үйл ажиллагаа, салбар хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлж, мэдээ, мэдээлэл, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах;

3.2.2. Үндэсний түвшинд коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шат, түвшинг 7 хоног тутам үнэлж, Засгийн газрын 2022 оны 01 дүгээр тогтоолын дагуу хариу арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах;

3.2.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын өдөр тутмын мэдээ, мэдээллээр холбогдох байгууллагыг хангах;

3.2.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх, сэргийлэх, тандах, бэлэн байдлыг хангах, шуурхай хариу арга хэмжээ авах чиглэлээр журам, зааврын төслийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх;

3.2.5. Өвчлөлийн нөхцөл байдал, ДЭМБ-ын түр заавар, удирдамжтай уялдуулан тандалт, хариу арга хэмжээний зааврыг тухай бүр нь шинэчлэн боловсруулах;

3.2.6. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын бэлэн байдлыг хангах, шуурхай хариу арга хэмжээг эрчимжүүлэх талаар эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэгт хяналт хийх;

3.2.7. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын эх уурхайг судлах, хавьтлыг тогтоох, ялангуяа хувилбарын сэжигтэй тохиолдолд хавьтал мөшгих замаар халдварын гинжин хэлхээг таслах, голомтын цар хүрээг тодорхойлох, тархалтын үе шатанд тохирсон тандалт, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр мэргэжил арга зүйгээр хангах;

3.2.8. Коронавируст халдварын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, ЭМЯ, аймаг, нийслэлийн ЭМГ, шуурхай штаб, олон улсын байгууллагуудыг 7 хоног тутам мэдээллээр хангах;

3.2.9. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн болон бусад салбарын ажилтнуудад халдвараас сэргийлэх дэглэм, хариу арга хэмжээний талаар мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.2.10. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, хариу арга хэмжээ, оношилгоо, эмчилгээний талаар аймаг, нийслэлийн тохиолдлын удирдлагын багийг сургах;

3.2.11. Томуу, томуу төст өвчний харуулдан тандалт болон SARS-CoV-2 вирусийг хянах нэгдсэн тандалтыг өргөжүүлэх, эрхзүйн орчинг сайжруулах;

3.2.12. Томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийн шинжилгээний сорьцын тоог нэмэгдүүлэх, хэвтэн эмчлүүлэгсдээс авсан коронавируст халдвар илрүүлэх сорьцонд түүвэр аргаар томуу, томуу төст өвчний үүсгэгчийг тандах шинжилгээ хийж байх;

3.2.13. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтод ажиллах хариу арга хэмжээний болон тусламж, үйлчилгээний багийг томилон ажиллуулах, сургах;

3.2.14. Үндэсний түвшинд лабораторийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, шинжилгээний сорьц хуваарилах, баталгаажуулах;

3.2.15. Лабораторийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, биоаюулгүй ажиллагаа, биохамгаалал, чанарын хяналт хийх, мэргэжилтнүүдийг сургах;

3.2.16. Хүн амын дунд орчилд байгаа SARS-CoV2 вирусийн генотипийн судалгаа хийх, мутацид орсон вирусийг илрүүлэх, хянах, мэдээлэх;

3.2.17. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой болон эрүүл мэндийн ажилтны халдварын тандалт хийх, хариу арга хэмжээ авах, халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр бүх шатны эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил аргазүйгээр хангах;

3.2.18. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах;

3.2.19. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын дараах дархлал тогтоцын судалгааг хийж, цаашдын вакцинжуулалтын стратеги боловсруулах;

3.2.20. Тусгаарлан эмчлэх эмнэлгийн бэлэн байдлыг хангаж, орны зохицуулалт, нэмэлтээр ор дэлгэх, үндэсний түвшинд мэргэжил арга зүйгээр ханган ажиллах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

3.2.21. Эмнэлгийн бус байранд эмнэлгийн ор дэлгэх үеийн зохион байгуулалт, халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.2.22. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдол, лаборатори, тандалт хяналтын мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэж дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах;

3.2.23. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлзүй болон сэргийлэлтийн талаар нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөөг олон нийтэд тогтмол өгөх;

3.2.24. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаар иргэдэд мэдээлэл өгөх утсыг 7/24 цагаар ажиллуулж, ташаа мэдээ, мэдээллийг тухай бүр нь залруулах;

3.2.25. Нас баралтын бүртгэлийг өдөр тутам нэгтгэж, дүн шинжилгээг 7 хоног тутам хийж, зөвлөмж зөвлөгөөгөөр эрүүл мэндийн байгууллагуудыг хангах;

3.2.26. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд тандалт, судалгаа хийж, тухай бүр тайлбар, залруулга хийх;

3.2.27. Эрсдэлийн мэдээлэл харилцааг эрчимжүүлж, өдөр тутмын нөхцөл байдалтай уялдуулан зөвлөмж, сэрэмжлүүлэг гарган түгээх.

3.3. Зоонозын өвчин судлалын үндэсний төв:

3.3.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгон хэрэгжүүлэх, мэргэжлийн анги, тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхжүүлэх;

3.3.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед суурин болон явуулын лабораторийн бэлэн байдлыг хангаж, лабораторийн шинжилгээ хийх;

3.3.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийх, тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллах, зохицуулалт хийх;

3.3.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын халдварын дайчлагдан ажиллах хүний нөөцийг чадавхжуулах;

3.3.5. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх биоаюулгүй ажиллагаа, халдваргүйжүүлэлтийн сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах;

3.3.6. Төв эмнэлэг, тусгай мэргэшлийн төв, аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагуудад коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтын болон эцсийн халдваргүйжүүлэлтийн давтан болон дадлагажуулах сургалт хийх;

3.3.7. Мал эмнэлгийн болон холбогдох байгууллагатай хамтран коронавируст халдвар (КОВИД-19)-ын судалгааг мал, амьтдын дунд улирал тутам тандан судлах;

3.3.8. Ариутгал, халдваргүйжүүлэх бодисын нөөцийн судалгааг гарган холбогдох байгууллагад хүргүүлэх;

3.3.9. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед хийгдэх халдваргүйжүүлэлтийн талаар эрүүл мэндийн болон салбар хоорондын байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангах, цаашдын стратеги боловсруулах;

3.3.10. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаар иргэдэд мэдээлэл өгөх 70284393 утсыг 7/24 цагаар ажиллуулж, иргэдээс ирүүлж буй мэдээлэлд дүн шинжилгээ хийн ташаа мэдээллийг тухай бүр залруулах;

3.3.11. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд тандалт, судалгаа хийж, тухай бүр тайлбар, залруулга хийх;

3.3.12. Эрсдэлийн мэдээлэл харилцааг эрчимжүүлж, өдөр тутмын нөхцөл байдалтай уялдуулан зөвлөмж, сэрэмжлүүлэг гарган түгээх.

3.4. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв:

3.4.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эрсдэлийн харилцааг сайжруулах арга хэмжээг үндэсний түвшинд зохион байгуулах;

3.4.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаарх хүн амын дундах ойлголт, хандлагыг тандан судалж, "түгээмэл асуулт, хариулт"-ыг өдөр бүр гаргаж, олон нийтэд мэдээлэх;

3.4.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эрсдэлийн харилцааны чиглэлээр сургалт зохион байгуулах;

3.4.4. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд тандалт, судалгаа хийж, тухай бүр тайлбар, залруулга хийх;

3.4.5. Эрсдэлийн мэдээлэл харилцааг эрчимжүүлж, өдөр тутмын нөхцөл байдалтай уялдуулан зөвлөмж, сэрэмжлүүлэг гарган түгээх;

3.4.6. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаар иргэдэд мэдээлэл өгөх 119 тусгай дугаарын утсыг нэгдсэн зохицуулалтаар хангах, тайланг өдөр бүр ЭМЯ-нд ирүүлэх;

3.4.7. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаарх хэвлэлийн тандалт хийх, ташаа мэдээ, мэдээллийг тухай бүр нь залруулах;

3.4.8. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед лабораторийн бэлэн байдлыг хангаж, лабораторийн шинжилгээ хийх;

3.4.9. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хүн амын дундах өргөжүүлсэн тандалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийх.

3.5. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв:

3.5.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед нийгмийн сэтгэлзүйн байдлыг тандаж судлан, зөвлөгөө зөвлөмжөөр ханган ажиллаж, тайланг ЭМЯ-нд ирүүлэх;

3.5.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн сэтгэлзүйн төрөлжсөн зөвлөмж (эрүүл мэндийн ажилтан, өвчтөн, сахиур, хавьтал) боловсруулж, зорилтот бүлэгт хүргэх;

3.5.3. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай, хяналтын өвчтөн, тэдгээрийн гэр бүлд хяналт тавьж, коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх зөвлөгөө, зөвлөмжөөр тогтмол хангах;

3.5.4. Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр зөвлөгөө өгөх 24 цагийн утас ажиллуулах.

3.6. Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар:

3.6.1. Орон нутгийн хэмжээнд коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшинг 7 хоног тутам үнэлж, Засгийн газрын 2022 оны 01 дүгээр тогтоолын дагуу хариу арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах;

3.6.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх, сэргийлэх, бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж, тандалт, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

3.6.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын эх уурхай, хавьтлыг судлан тогтоох, хувилбарын сэжигтэй тохиолдлуудад хавьтал мөшгөх замаар халдварын гинжин хэлхээг таслах, кластер өвчлөлийг нарийвчлан тандах, голомтын цар хүрээг тодорхойлох, хариу арга хэмжээг шуурхай авах;

3.6.4. Коронавируст халдварыг илрүүлэх шинжилгээний цэг байгуулан ажиллах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

3.6.5. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, тусламж үйлчилгээг нэгдсэн зохицуулалтаар хангах мэргэжлийн багийг байгуулан ажиллуулах;

3.6.6. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, зорилтот бүлгийн иргэдийг бүрэн хамруулах;

3.6.7. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн судалгааг хийж, ХӨСҮТ-д мэдээлэх;

3.6.8. Тусгаарлан эмчлэх эмнэлгүүдийн бэлэн байдлыг хангах, орны зохицуулалт хийх, нэмэлтээр ор дэлгэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

3.6.9. Шаардлагатай тохиолдолд эмнэлгийн бус байранд эмнэлгийн ор дэлгэж, тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллах;

3.6.10. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаарх хариу арга хэмжээний багуудын мэдээ, мэдээллийг нэгтгэн, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах;

3.6.11. КОВИД-19 амбулатори ажиллуулах;

3.6.12. Эмнэлгийн тусламж үйлчилгээ, хариу арга хэмжээний багийн хамгаалах хувцас хэрэгсэл, эм урвалж бодис, оношлуур, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйжүүлэх бодисын нөөц, хэрэгцээг тогтмол үнэлж, бэлэн байдлыг хангах.

3.7. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага:

3.7.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх, сэргийлэх, бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж хэрэгжүүлэх;

3.7.2. Томуу томуу төст өвчин, амьсгалын замын цочмог хүнд халдварын тандалтыг өргөжүүлэх, халдварын сэргийлэлт, хяналтын багийн үйл ажиллагааг тогтмолжуулах;

3.7.3. Эрүүл мэндийн байгууллага бүр эрсдэлийн үнэлгээг тухай бүр (нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ авахаас өмнө, дараа, тархалтын түвшин өөрчлөгдөх г.м) хийж, халдвараас сэргийлэх арга хэмжээг авах;

3.7.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг түр тусгаарлах, эмчлэх өрөө, тасгийг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалын 9 дүгээр хавсралтын дагуу зохион байгуулах;

3.7.5. Хувь хүн өөрийгөө антигенд суурилсан түргэвчилсэн тестээр оношилж эерэг гарсан тохиолдолд өрхийн эрүүл мэндийн төвд хандан давтан хийлгэж, эерэг бол тандалтын цахим системд бүртгэх;

3.7.6. Эмнэлэгт эмнэлзүйн шинж тэмдэггүй, коронавирүс илрүүлэх шинжилгээнд хамрагдаагүй эмчлүүлэгчийг тусгай өрөө, тасаг нээж, тусламж үйлчилгээг үзүүлэх;

3.7.7. Эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгчдийн дунд лабораторид суурилсан тандалт хийх;

3.7.8. Үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилтнуудын дунд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлзүйн шинж тэмдгийн тандалтыг өдөр бүр хийх;

3.7.9. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай багаж хэрэгсэл, эм, урвалж бодис, эрүүл мэндийн ажилтныг хувийн хамгаалах хувцас, хэрэгслээр хангах;

3.7.10. Үйлчлүүлэгчдийн биеийн халууныг хэмжиж, QR код эсхүл үйлчлүүлэгчийн овог нэр, регистрийн дугаар, утас, оршин суугаа хаягийн бүртгэл хийх;

3.7.11. Үйлчлүүлэгчийн эмнэлэгт ирэх хөдөлгөөнийг бууруулж, байнгын хяналтад байдаг зорилтот бүлгийн иргэнд цахимаар зөвлөгөө өгөх, хяналт тавих, гэрээр эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх зохицуулалт хийх;

3.7.12. Өвчтөний өрөөнд орох эмнэлгийн ажилтны тоог хязгаарлах, орсон гарсан хүний бүртгэл хөтлөх;

3.7.13. Халдварын сэжигтэй тохиолдол харьяа нутаг дэвсгэр, хилийн боомтод илэрвэл мэргэжлийн багийг илгээж, хариу арга хэмжээг салбар хоорондын байгууллагуудтай хамтран шуурхай авч хэрэгжүүлэх;

3.7.14. Эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэхдээ өвчтөний аюулгүй байдлыг хангах;

3.7.15. Хөтөч ажилтанг ажиллуулж, халдварын шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчийг тусгаарлах өрөө рүү чиглүүлэн, бусад үйлчлүүлэгчтэй хавьтал болохоос сэргийлэх;

3.7.16. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж буй хүнд зай барих, амны хаалт зүүх, гарын эрүүл ахуй сахих, зөв ханиаж, найтаах санамж, анхааруулга өгөх;

3.7.17. Амбулатори, хүлээн авах, яаралтай тусламжийн хэсэгт хэт ачаалал үүсэхээс сэргийлж, эмнэл зүйн шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчийг бусад үйлчлүүлэгчээс тусад нь хүлээн авах бүстэй байхаар зохион байгуулах;

3.7.18. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтод байнгын болон эцсийн халдваргүйжүүлэлт хийх;

3.7.19. Тусгаарлан ажиглах байрны бэлэн байдлыг хангах, нэмэлт ор дэлгэх зэрэг шаардлагатай арга хэмжээнд харьяа засаг захиргаа, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.

3.8. Иргэний агаарын болон төмөр зам, нийтийн тээврийн газар:

3.8.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж хэрэгжүүлэх;

3.8.2. Нисэх онгоцны буудал, авто, төмөр замын зорчигч үйлчилгээний төвүүдэд коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөө, галт тэрэг, агаарын хөлөгт тусгаарлах хэсгийг бэлтгэж, бэлэн байдлыг хангах;

3.8.3. Зорчигч тээврийн байгууллага аяллын явцад зорчигчдын эрүүл мэндэд хяналт тавьж, сэжигтэй тохиолдол илэрсэн үед холбогдох байгууллагад нэн даруй мэдээлж, зохих хариу арга хэмжээ авах;

3.8.4. Халдвар бүртгэгдсэн улс, орон нутаг руу аялал хийх тээврийн хэрэгслийн багийг хамгаалах хувцас, хэрэгсэл, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйжүүлэх бодисоор хангах;

3.8.5. Ажилтанд урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн дэглэм сахих талаар сургалт зохион байгуулж, амны хаалт, гар халдваргүйжүүлэх бодисоор тогтмол хангах;

3.8.6. Ариун цэврийн өрөө, гар угаах нөхцөлийг бүрдүүлж, үйлчилгээний танхим, ариун цэврийн өрөөнд гар халдваргүйжүүлэгч бодисыг хүрэлцэхүйц тоо, хэмжээгээр байршуулах;

3.8.7. Мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмжийг урсдаг цахим самбар болон бусад хэлбэрээр байршуулах, зорчигчдод халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж өгөх;

3.8.8. Үйлчлүүлэгчдийн биеийн халууныг зайнаас хэмжиж, амны хаалт зүүсэн зорчигчдод үйлчлэх.

3.9. Хилийн нэвтрэх цэг:

3.9.1. Хилийн нэвтрэх цэгт Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийх, хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.9.2. Дэлхий дахинд SARS-CoV-2 вирусийн анхаарал татсан хувилбар шинээр мэдээлэгдсэн тохиолдолд хилийн нэвтрэх цэгт лабораторид суурилсан тандалт хийх;

3.9.3. Хилийн нэвтрэх цэгт сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэлтийн багаж, бодис, эмийн нөөцийг МХЕГ-ын даргын 2018 оны "Заавар батлах тухай" А/192 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан шаардлагын дагуу бүрдүүлж, бэлэн байдлыг хангах;

3.9.4. Агаарын хилийн боомт дээр Иргэний нисэхийн ерөнхий газрын дэргэдэх APIS (Advance passenger information system) цахим программын тусламжаар зорчигчийн мэдээллийг урьдчилан авч, хариу арга хэмжээг төлөвлөх;

3.9.5. Онгоцны нисэх багийн даргаас зорчигчийн эрүүл мэндийн ерөнхий мэдүүлэг, (general declaration form) галт тэрэгний дарга, үйлчлэгч, автобус, автомашины жолоочоос зорчигчийн эрүүл мэндийн мэдээлэл, зорчигчийн тоо,

суудлын дугаар бүхий нэрсийн жагсаалтын хамт авч, хяналт тандалт хийх төлөвлөлтийг зохион байгуулах;

3.9.6. Улсын хилийн боомтоор нэвтэрч буй зорчигч, жолооч, нислэгийн баг бүрэлдэхүүн, галт тэрэг, вагоны дарга, үйлчлэгч, төмөр замын хөлөг ажилтнаас "Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг"-ийг (цахим хэлбэр) авч, биеийн халууныг хэмжин, хяналт тандалт хийх.

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТҮР ЗААВАР

Нэг. Хариу арга хэмжээний зохион байгуулалт

- 1.1. Улаанбаатар хотод Нийслэлийн эрүүл мэндийн газар, орон нутагт аймгийн эрүүл мэндийн газар нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, хариу арга хэмжээг зохион байгуулан ажиллана.
- 1.2. Халдварт өвчин судлалын үндэсний төв нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, хариу арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж ажиллана.
- 1.3. Аймаг, нийслэлийн ЭМГ, дүүргийн эрүүл мэндийн төв нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархвар судлалын судалгаа хийх тандалт, шуурхай хариу арга хэмжээний багийг сургаж бэлтгэн ажиллуулна.
- 1.4. Коронавируст халдвар (КОВИД-19) тархалтын үе шат, түвшингээс хамаарч, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь шуурхай хариу арга хэмжээний багийг нэмэлтээр гарган томилгоожуулна.
- 1.5. Батлагдсан тохиолдлын тархвар судлал, хавьтал судлал, хариу арга хэмжээг халдварын үе шат, тархалтын түвшинд тохируулан хийнэ.
- 1.6. Батлагдсан тохиолдлын тархвар судлалын мэдээллийг "tandalt.gov.mn" цахим системд оруулна.
- 1.7. Бх-ПГУ шинжилгээ болон антигенд суурилсан түргэвчилсэн оношлуураар эерэг коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлыг өдөр тутмын мэдээнд мэдээлж, tandalt.gov.mn цахим системийн мэдээллийн санд бүртгэнэ.

Хоёр. Шуурхай хариу арга хэмжээний багийн чиг үүрэг

- 2.1. Шуурхай хариу арга хэмжээний баг нь батлагдсан тохиолдлын мэдээллийн дагуу хариу арга хэмжээ авч ажиллана.
- 2.2. Батлагдсан тохиолдлоос тархвар судлалын судалгааны асуумжийн дагуу мэдээлэл цуглуулан, хавьтлыг тогтоон, тандалтын цахим программд оруулна.
- 2.3. Шуурхай хариу арга хэмжээний баг нь батлагдсан тохиолдол, хавьталд эмчийн үзлэг хийж, эрэмбэлэн ангилж, эмнэлзүйн хүндэвтэр, хүнд болон маш хүнд тохиолдлыг эмнэлэгт, хөнгөн хэлбэрийг гэрээр тусгаарлан зөвлөгөө өгнө.
- 2.4. Шинж тэмдэг илэрсэн хавьталд эмнэлзүй, тархвар судлалын асуумжид үндэслэн антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээ хийж, эерэг гарсан тохиолдлыг тусгаарлана.
- 2.5. Шуурхай хариу арга хэмжээний баг нь 24 цагийн тайланг тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын удирдлагад мэдээлнэ.

Гурав. Тандалтын багийн үүрэг

- 3.1. Батлагдсан тохиолдлын мэдээллийг авч тархвар судлалын судалгааг шуурхай зохион байгуулж, тандалтын системд оруулна. Тархвар судалгаагаар халдварын эх уурхай, голомтын мэдээлэл, ойрын хавьтлын судалгаа хийж бүртгэнэ.

3.2. Батлагдсан тохиолдол нь ойрын хавьтал, тархвар судлалын мэдээллээ бүрэн өгөөгүй тохиолдолд судалгааг дахин хийнэ.

3.3. Жирэмсэн эмэгтэй, хүүхэд, вакцины бүрэн тунд хамрагдсаны дараах батлагдсан, зөөвөрлөгдсөн тохиолдлын нэмэлт судалгааг хийнэ.

3.4. Өдөр бүр батлагдсан тохиолдол, ойрын хавьтал, эх уурхай, голомт, нас баралт зэрэг мэдээллийг нэгтгэн дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад хугацаанд нь бүрэн мэдээлнэ.

3.5. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын байдалд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлт гаргана.

Дөрөв. Эрүүл мэндийн байгууллагад сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах хариу арга хэмжээ

4.1. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага бүр коронавируст халдвар (КОВИД-19)-ын хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.

4.2. Үзлэгийн явцад коронавируст халдвар (КОВИД-19) гэж сэжиглэсэн тохиолдолд эмч тухайн өрөөнд гарах, орох хөдөлгөөнийг түр зогсоож, бусад хүмүүсээс дор хаяж 1.5 метрээс хол зайд түр тусгаарлана.

4.3. Эрүүл мэндийн байгууллагын удирдлагад мэдээлж, тухайн иргэнийг түр тусгаарлан сорьц авч, шинжилгээний хариу гарах хүртэл шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлнэ.

4.5. Сэжигтэй тохиолдол илэрсэн тухай мэдээг "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, сэргийлэлтийн түр заавар"-т тусгасан бүртгэл, мэдээллийн дагуу харьяа дүүрэг, аймгийн ЭМГ-т мэдээлнэ.

Тав. Халдвар тархалтын түвшинд тохирсон хариу арга хэмжээ

5.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын халдварын тархалтын үе шатнаас хамаарч дараах арга хэмжээг зохион байгуулна (Хүснэгт).

Хүснэгт. Коронавируст халдвар (КОВИД-19) тархалтын түвшинд тохирсон хариу арга хэмжээ

Авах арга хэмжээний чиглэл	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшин			
	Халдвар илрээгүй (ногоон)	Зөөвөрлөгдсөн/алаг цоог тохиолдол бүртгэгдсэн (шар)	Халдаар голомтлон тархсан (кластер) (улбар шар)	Халдаар хүн амын дунд өргөн тархсан (улаан)
Хилийн нэвтрэх цэгийн тандалт	Хилийн нэвтрэх цэгийн тандалт хийх	Хилийн нэвтрэх цэгийн тандалт хийх	Шаардлагагүй	Шаардлагагүй
Идэвхтэй тандалт	- Амбулаториор үйлчлүүлэгчдийн дунд ТТӨ-ий тандалт хийх; - Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа 16-аас доош насны хүүхдийн АЗЦХХ-ын тандалт хийх.	Ногоон түвшингийн арга хэмжээн дээр нэмж - Өндөр эрсдэлтэй эрүүл мэндийн болон үйлчилгээний байгууллагын ажиллагсад шинж тэмдгийн, ирцийн,	Шар түвшингийн арга хэмжээн дээр нэмж - Асрамж, хорих саатуулах газар, цэргийн анги зэрэг хаалттай орчин.	- Хүүхдийн байгууллага - Хаалттай орчин - Стратегийн аж холбогдолтой үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага

		лабораторит суурилсан тандалт хийх.	- Эмнэлэгт суурилсан тандалт хийх.	- Эрүүл мэндийн байгууллагын тандалт хийх.
Тохиолдол, кластер өвчлөлийн тархвар судалгаа	-	Батлагдсан тохиолдол бүрийн тархвар судалгааг нарийвчлан хийж хавьтлыг тогтоох	Шар түвшингийн арга хэмжээн дээр нэмж - Айл өрх, албан байгууллагад бүртгэгдэж байгаа кластер халдвар бүрийг бүртгэн тархвар судалгаа хийх; - Шинэ голомтын судалгаа хийх.	- Тархвар судалгааг эрсдэлт бүлэгт чиглүүлэн хийх; - Олон хүн өвчлөх эрсдэлтэй байгууллага, стратегич холбогдол бүхий газар, эрүүл мэндийн байгууллагад тандалт хийх.
Тусгайлсан тандалт судалгаа	-	- Батлагдсан тохиолдлын вакцинжуулалт; - Давтан халдвар; - Нас баралт; - Хувилбарын тандалт - Дархлал тогтоцын судалгааг хийнэ.		
Батлагдсан тохиолдлын тусгаарлалт	-	Сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдол бүрийг эмнэлэгт тусгаарлаж эмчлэх.	Батлагдсан тохиолдол бүрийг эмнэлэгт тусгаарлаж эмчлэх (Орны ачааллаас хамаарах).	- Эмнэлзүйн хүндэтгэл, хүнд, маш хүнд хэлбэрийн өвчтнийг эмнэлэгт тусгаарлаж эмчлэх; - Хөнгөн, эмнэлзүйн шинж тэмдэггүй бол гэрт нь тусгаарлаж эмчлэх.
Хавьтлын хэл хосло, шинжилгээ	-	- Тусгаарлан ажиглах байр, боломжгүй бол гэрийн тусгаарлалтад 5 хоног байлгах; - Шинж тэмдэг илэрсэн бол антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээ эсвэл бх-ПГУ хийх; - Эмнэлзүйн шинж тэмдэг илрээгүй бол шинжилгээ шаардлагагүй.	- Гэрийн тусгаарлалтад 5 хоног байлгах; - Шинж тэмдэг илэрсэн бол антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээ эсвэл бх-ПГУ хийх; - Эмнэлзүйн шинж тэмдэг илрээгүй бол шинжилгээ шаардлагагүй.	- Гэрийн тусгаарлалтад 5 хоног байлгах - Шинж тэмдэг илэрвэл эмнэлзүйгээр оношилж болно.
Гадаадаас ирсэн иргэдийн тусгаарлалт	Халдварын эрсдэлтэй бүс нутгаас ирсэн иргэдийг.	- Гэрийн тусгаарлалтад 5 хоног тусгаарлах; - Хилийн нэвтрэх цэгт бх-ПГУ эсхүл	- Гэрийн тусгаарлалтад 5 хоног тусгаарлах.	Олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцохдоо халдвараас

	<ul style="list-style-type: none"> - Тусгаарлан ажиглах байранд тусгаарлах; - Хилийн нээтрэх цэгт бх-ПГУ эсхүл антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээнд хамруулах; - Орон нутгийн авто замын пост дээр тархвар судлалын болон эмнэлзүйн асуумж судалгаа, антигенд түргэвчилсэн шинжилгээ хийх. 	<p>антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээнд хамруулах.</p> <ul style="list-style-type: none"> - Орон нутгийн авто замын пост дээр тархвар судлалын болон эмнэлзүйн асуумж судалгаа, антигенд түргэвчилсэн шинжилгээ хийх. 	<ul style="list-style-type: none"> - Эмнэлзүйн шинж тэмдгийн тандалт хийх; - Шинж тэмдэгтэй бол бх-ПГУ шинжилгээнд хамруулах. 	сэргийлэх дэглэм баримтлах.
Сэжигтэй, магадлалтай тохиолдол	Шинж тэмдэг илэрмэгц бх-ПГУ шинжилгээ	Шинж тэмдэг илэрмэгц антиген суурилсан түргэвчилсэн шинжилгээ сөрөг бол бх-ПГУ шинжилгээ	Шинж тэмдэг илэрмэгц антиген суурилсан түргэвчилсэн шинжилгээ сөрөг бол бх-ПГУ шинжилгээ	Шинж тэмдэг илэрмэгц антиген суурилсан түргэвчилсэн шинжилгээ сөрөг бол бх-ПГУ шинжилгээ

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ТАНДАЛТ ХИЙХ ТҮР ЗААВАР

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Эрүүл мэндийн байгууллагад коронавируст халдвар (КОВИД-19) голомтлон тархахаас сэргийлж, эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгчдийн дунд лабораторит суурилсан болон шинж тэмдгийн идэвхтэй тандалт хийж, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэхэд энэхүү зааврыг мөрдөнө.

Хоёр. Эмнэлзүйн шинж тэмдгийн тандалт хийх

2.1. Эрүүл мэндийн ажилтан, албан хаагчдын ирцийн тандалтыг өдөр бүр хийж, ажилдаа ирээгүй тохиолдолд шалтгааныг тодруулж бүртгэлжүүлнэ.

2.2. Эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгчдэд өдөр бүр эмнэлзүйн шинж тэмдгийн тандалт хийж, биеийн халууныг үзэж тэмдэглэнэ.

2.3. Эмнэлэгт хэвтэх үед нь үйлчлүүлэгчид шинж тэмдгийн тандалт хийж, биеийн халууныг үзэн, тархвар судлалын асуумжаар сүүлийн 4 хоногт халдвартай хүнтэй ойрын хавьтал болсон эсэх, халдвар бүртгэгдсэн бүс нутагт зорчсон эсэхийг тодруулна.

Гурав. Лабораторит суурилсан тандалт хийх

3.1. Эрүүл мэндийн ажилтан болон үйлчлүүлэгчээс эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд вакцинд хамрагдсан эсэхээс үл хамаарч хугацаа харгалзахгүй нэн даруй шинжилгээнд хамруулна.

3.2. Халдварт өртөх өндөр эрсдэлтэй эрхтэн шилжүүлэн суулгасан, дархлаа дарангуйлагдсан, вакцинд хамрагдаагүй 12-оос доош насны хүүхэд, эх, нярай зэрэг тасаг нэгжийн хэвтэн эмчлүүлэгч, гемодиализ, хими, туяа гэх мэт байнгын эмчилгээ хийлгэдэг иргэд болон тухайн тасаг, нэгжийн ажилтнаас түүвэрлэн тодорхой давтамжтайгаар шинжилгээнд хамруулна.

3.3. Дээр дурдсан тасаг нэгжийн ажилтан болон эмчлүүлэгчийн 30 хүртэл хувийг 7 хоногийн давтамжтайгаар тандалтын шинжилгээнд хамруулна.

Дөрөв. Бүртгэж, мэдээлэх

4.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой коронавируст халдвар (КОВИД-19)-т өртсөн үйлчлүүлэгчийн мэдээллийг хүснэгт 1-ийн дагуу, коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвдсөн эрүүл мэндийн ажилтны мэдээллийг хүснэгт 2-ийн дагуу бүртгэнэ.

4.2. Бүртгэгдсэн тохиолдлын мэдээг болон халдварын голомтод авсан хариу арга хэмжээний тайлангийн хамт 7 хоног бүрийн Баасан гарагт ХӨСҮТ-ийн ipc@ncod.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

**Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой коронавируст
халдвар (КОВИД-19)-т өртсөн үйлчлүүлэгчийн
мэдээллийн хүснэгт**

Хүснэгт 1

№	Үйлчлүүлэгчийн овог нэр	Нас	Хүйс	Регистрийн дугаар	ЭМБ-ын нэр	Эмнэлэгт хэвтсэн огноо	Тусламж үйлчилгээний нэр	Халдварын шинж тэмдэг илэрсэн огноо	Лабораторийн шинжилгээний төрөл	Батлагдсан огноо	Вакцины нэр	КОВИД-19 өсрэг вакцины тун			Тавигдан
												1 тун	2 тун	3 тун	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16

**Коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилсөн
эрүүл мэндийн ажилтны тандалтын асуумж**

Хүснэгт 2

№	Овог	Нэр	Нас	Хүйс	Регистрийн дугаар	Эрүүл мэндийн байгуулалтын нэр	Тасаг, нэгж	Албан тушаал	Халдварт өртсөн шалтгаан	ЭТҮХХ мөн эсэх	Халдвар батлагдсан огноо			Вакцинд хамрагдсан эсэх	Вакцины тунгийн тоо	Сүүлийн тун хийгээсэн огноо	Вакцины нэр
											I	II	III				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18

Жич: Халдварт өртсөн шалтгааныг дараах байдлаар тооцно.

- Тусгаарлах эмнэлэг, тасагт ажиллах үед – Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөнийг тусгаарлан эмчлэх эмнэлэг, тасагт ажиллах үедээ халдварт өртсөн бол;
- Коронавируст халдвар (КОВИД-19) батлагдсан өвчтөнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх үед;
- Коронавируст халдвар (КОВИД-19) оношлогдоогүй үед – эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх үедээ халдварт өртсөн бол;
- Коронавируст халдвар (КОВИД-19) илрүүлэх сорьц цуглуулах үед- хамар-залгиурын арчдас, ам-залгиурын арчдасын сорьц цуглуулах үед халдварт өртсөн бол;
- Лабораторид ажиллаж байхдаа - Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үүсгэгч илрүүлэх лабораторид ажиллах үед халдварт өртсөн бол;
- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтод халдваргүйжүүлэлт хийх үед;
- Коронавируст халдвар (КОВИД-19)-тай үйлчлүүлэгчийг зөвөөрлөх үед;
- Хамт ажилладаг ажилтнаас халдвар авсан, ажил үүргээ гүйцэтгэхдээ Коронавируст халдвар (КОВИД-19)-тай эмнэлгийн ажилтантай хавьтал болсон үед;
- Ажил үүргээ гүйцэтгэх үед - Коронавируст халдвар (КОВИД-19)-ын бус тусламж үйлчилгээний явцад халдварт өртөх эрсдэлтэй гэж тооцсон үед;
- Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөнд хэрэглэсэн багаж хэрэгсэл, эд зүйлс, хог хаягдалтай харьцсан, халдвартай өвчтөний цогцостой харьцсан гэх мэт үүнтэй адилтгах шалтгаанаар халдварт өртсөн тохиолдолд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараар бүртгэнэ.
- Гэр бүл, найз нөхдийн хавьтал, эмнэлгийн бус орчинд, тодорхойгүй зэрэг тохиолдолд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоогүй гэж бүртгэнэ.

**ХААЛТТАЙ ОРЧИН (АСРАМЖИЙН ГАЗАР, ЦЭРГИЙН АНГИ, ХОРИХ
АНГИ, УУЛ УУРХАЙН КЭМП, ҮЙЛДВЭР)-Д
ТАНДАЛТ ХИЙХ ТҮР ЗААВАР**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Асрамжийн газар, цэргийн анги, хорих, саатуулах байр, уул уурхайн кэмп зэрэг хаалттай орчинд коронавируст халдвар (КОВИД-19)-ыг эрт илрүүлэх, халдвар тархахаас сэргийлэх зорилгоор идэвхтэй тандалт хийж хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэхэд энэхүү зааврыг мөрдөнө.

1.2. Байгууллага бүр коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед ажиллах тандалт, шуурхай хариу арга хэмжээний багийг удирдлагын шийдвэрээр томилсон байна.

1.3. Тандалт, шуурхай хариу арга хэмжээний багийг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрүүл мэндийн ажилтан, хүний нөөц болон бусад мэргэжилтнийг оролцуулан байгуулж мэргэжлийн байгууллагаас сургалт, арга зүйн зөвлөмж авсан байна.

1.4. Аймаг, дүүрэг, сумын эрүүл мэндийн байгууллага ХӨСҮТ-ийн мэргэжил арга зүйн удирдлага дор харьяа газар нутагт байгаа хорих газар, асрамжийн газар, үйлдвэрийн газар, уул уурхайн кэмпд идэвхтэй тандалт хийж, мэргэжил арга зүйгээр ханган, халдварын эрсдэлийг тооцож, тандалт хариу арга хэмжээг зохион байгуулна.

1.5. Нийслэлд ХӨСҮТ-ийн тандалтын баг ажиллаж, хэрэв орон нутагт өндөр эрсдэл бүхий байгууллагад кластер өвчлөл бүртгэгдвэл мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж, шаардлагатай бол баг томилон ажиллуулна.

1.6. Халдварын сэжигтэй, батлагдсан тохиолдол, ойрын хавьтлыг тусгаарлах өрөөг бэлтгэнэ.

1.7. Асруулагч, алба хаагч, хүмүүжигч нарт эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, халдваргүйжүүлэх бодис, хамгаалах хувцас хэрэгсэл болон антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээ хийх оношлуурын нөөцийг бүрдүүлнэ.

Хоёр. Албан хаагчдад тандалт хийх

2.1. Ажилтнуудад өдөр бүр шинж тэмдгийн тандалт хийж биеийн халууныг хэмжиж, тэмдэглэл хөтөлнө.

2.2. Ажилчдын ирцийг бүртгэж, ажилдаа ирээгүй шалтгааныг тодруулна.

2.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд тусгаарлаж, түргэвчилсэн шинжилгээ хийнэ.

2.4. Халдварын шинж тэмдэг илэрч түргэвчилсэн шинжилгээний хариу сөрөг гарсан тохиолдолд бх-ПГУ шинжилгээ авна.

2.5. Тандалтын зорилгоор ажилтнуудын 20-30 хувьд 14 хоногийн давтамжтайгаар түргэвчилсэн шинжилгээ хийнэ.

Гурав. Асрамжийн газрын үйлчлүүлэгч, цэргийн ангийн алба хаагч, хорих газрын хүмүүжигчдэд идэвхтэй тандалт хийх

3.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинж тэмдгийн тандалтыг өдөр бүр хийж, шинж тэмдэг илэрсэн тохиолдолд тусгаарлаж, шинжилгээнд хамруулна.

3.2. Халдварын шинж тэмдэг илэрсэн сэжигтэй тохиолдолд түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийж эерэг гарсан тохиолдлыг 24 цагийн дотор харьяа эрүүл мэндийн байгууллагад мэдээлнэ.

3.3. Халдварын шинж тэмдэг илэрч антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээний хариу сөрөг эсхүл эргэлзээтэй гарсан тохиолдолд бх-ПГУ шинжилгээ авна.

3.4. Тандалтын зорилгоор хаалттай орчинд байгаа иргэдийн 10-20 хувьд 14 хоногийн давтамжтайгаар түргэвчилсэн шинжилгээ хийнэ.

3.5. Ойрын хавьтлуудыг судлан тогтоож, өвчлөлийн тархалтаас хамаарч эрэмбэлэн ангилж тусгаарлалтыг зохион байгуулна.

3.6. Тусгаарлалтын хугацаанд ойрын хавьтлуудаас тусгаарлагдсан өдрөөс хойш 6 дахь хоногт түргэвчилсэн шинжилгээ авна.

3.7. Байгууллага бүр тусгаарлан эмчлэх хэсгийг зохион байгуулж, эмнэлзүйн шинж тэмдэггүй болон хөнгөн явцтай өвчтнийг тусгаарлан эмчлэнэ. Шаардлагатай тохиолдолд харьяа эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.

3.8. Орон нутгийн халдварын тархалтын түвшингээс хамаарч эргэлтийг хязгаарлах, эргэлтийн үед халдвараас сэргийлэх дэглэм мөрдүүлнэ.

КЛАСТЕР (БАГЦ) ӨВЧЛӨЛИЙН СУДАЛГАА ХИЙХ ТҮР ЗААВАР

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын кластер өвчлөлийг эрт илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагаанд дараах зааврыг мөрдөж ажиллана.

Хоёр. Тодорхойлолт

2.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын 5 ба түүнээс дээш, хоорондоо холбоотой тохиолдлыг кластер гэж үзнэ.

2.2. Амралтын газар, сувилал, асрамжийн газар, хорих анги, саатуулах байр зэрэг хаалттай орчинд коронавируст халдвар (КОВИД-19)-ын нэг тохиолдол батлагдвал кластер гэж үзнэ.

Гурав. Кластерийн төлөв

3.1. Идэвхтэй кластер – Сүүлийн 10 хоногийн хугацаанд шинэ тохиолдол бүртгэгдсэн буюу идэвхтэй халдвар илэрч байгаа бол;

3.2. Идэвхгүй кластер – Хамгийн сүүлд бүртгэгдсэн тохиолдлоос хойш 10 хоногийн хугацаанд шинэ тохиолдол бүртгэгдээгүй бол;

3.3. Хяналтаас хасагдсан кластер – Сүүлийн батлагдсан тохиолдол илэрснээс хойш 14 хоногийн хугацаанд шинэ тохиолдол илрээгүй бол.

Дөрөв. Кластерыг илрүүлэх, тандалт судалгаа хийх

4.1. Кластер өвчлөлийг илрүүлэх

4.1.1. Аймгийн ЭМГ, дүүргийн ЭМТ, ХӨСҮТ-ийн тандалтын баг нь кластер өвчлөлийн илрүүлэг, тандалт, хариу арга хэмжээг зохион байгуулна.

4.1.2. Кластер өвчлөлийг идэвхтэй болон идэвхгүй тандалт, үйл явдалд суурилсан тандалтаар илрүүлнэ.

4.1.3. Батлагдсан тохиолдлын тархвар судлалын асуумж судалгааг оршин суугаа нутаг дэвсгэр, ажлын газар, явсан маршрут, үзвэр үйлчилгээ, олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцсон, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн гэх мэтээр тандалтын мэдээллийг бүлэглэн судалж, кластер өвчлөлийг илрүүлнэ.

4.1.4. Кластер өвчлөлийг үйл явдалд суурилсан тандалтаар илрүүлж, шуурхай хариу арга хэмжээ авна.

4.2. Кластер өвчлөлийг бүртгэх

4.2.1. Кластерийн бүртгэлийг “Хүснэгт 1”-ийн дагуу бүртгэн, мэдээллийг өдөр бүр шинэчилнэ.

4.2.2. Кластерийн судалгаанд дараах мэдээллүүдийг хавсаргана.

Үүнд:

- Кластерийн зураглал/хавьтлын мод
- Идэвхтэй кластерийн тоо
- Кластерт бүртгэгдсэн батлагдсан тохиолдлын тоо

- Тусгаарлагдсан ойрын хавьтлын тоо
- Ойрын хавьтлаас шинээр илэрсэн тохиолдлын тоо
- Гэрээр хянагдаж буй батлагдсан тохиолдлын тоо

4.3. Кластерийг мэдээлэх, хариу арга хэмжээ авах

4.3.1. Аймгийн ЭМГ, дүүргийн ЭМТ, ХӨСҮТ нь кластерийн мэдээлэл, кластерийн төрлийг хүснэгт 1-ийн дагуу өдөр бүр бүртгэнэ.

4.3.2. Аймаг, дүүргийн эрүүл мэндийн газар, төв нь бүртгэгдсэн кластерийн мэдээллийг 7 хоног бүр нэгтгэн мэдээлнэ.

4.3.3. Тухайн дүүрэг, аймагт бүртгэгдсэн кластер өвчлөлийг 7 хоногийн мэдээг Бямба гаригаас Баасан гариг дуустал хугацаагаар тасалбар болгон Бямба гаригийн өдрийн 12 цагаас өмнө Халдварт өвчин судлалын үндэсний төвд covid0315@gmail.com гэсэн цахим хаягаар хүснэгт-2-ын дагуу мэдээлнэ.

4.3.4. Кластер өвчлөл байж болзошгүй тохиолдолд тархвар судалгааг яаралтай хийжхавьтлуудыг шинжилгээнд хамруулах, халдварын сэжигтэй тохиолдлыг тусгаарлах арга хэмжээ авна.

4.3.5. Халдварт өвчин судлалын үндэсний төв долоо хоног бүр кластерийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээг төлөвлөн, мэргэжил аргагүйгээр хангана.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын кластер өвчлөлийг бүртгэх хуудас

Хүснэгт 1

Байгууллагын нэр _____

№	Кластерийн нэр	Кластерийн төлөв	Эхний өвчлөл бүртгэгдсэн огноо	Сүүлийн өвчлөл бүртгэгдсэн огноо	Сүүлийн 24 цагт батлагдсан тохиолдлын тоо	Батлагдсан нийт тохиолдлын тоо /ессөн дүнгээр/	Хавьтлын тоо																		
							Гэр бүл		Ажил, сургууль, цэцэрлэг		Байр		Найз		Өвчтөн		Үйлчлү үлэгч		ЭМА		Бусад				
							Нийт	Сөрөг	Нийт	Сөрөг	Нийт	Сөрөг	Нийт	Сөрөг	Нийт	Сөрөг	Нийт	Сөрөг	Нийт	Сөрөг	Нийт	Сөрөг			

Кластер өвчлөлийг мэдээлэх хуудас

Эрүүл мэндийн байгууллагын нэр: _____
 Хяналт хийж байгаа эмчийн нэр: _____

Хүснэгт 2

№Оны, сарын, ...-ны байдлаар	Бэлчлэл бүртгэгдсэн байгууллага, газар																								
		Гомогтын нэр	Батлагдсан тохиолдлын тоо	Эрүүл мэндийн байгууллага	Гар бүл	Сувилал, амралтын газар	Тусгаарлах байр	Олон нийтийг хамарсан үйл ажиллагаа	Оршин суугаа газартай холбоотой	Нийтийн тээвэр	Асрамжийн газар	Цэргийн анги	Хорих анги	Баривчлах байр	Худалдааныг өв, зах	Баар, караоке	Нийтийн хоолны газартай холбоотой	Хүнсний дэлгүүр, худалдаатай холбоотой	Гоо сайхны салон, үйлчилгээ, үсчин	Сайн, бусад, баривчлалтай холбоотой	Сайн, бусад, баривчлалтай холбоотой	Барилгын компани, засвар үйлчилгээ	Улсуурхайн компани	Банк, санхүүгийн байгууллага	Бусад байгууллага, хамт олон	
1																										
2																										
3																										
4																										

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД МӨРДӨХ ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН ТҮР ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн байгууллага болон эрүүл мэндийн бус байгууллагын барилга байгууламжийг ашиглан эмнэлэг дэлгэж, коронавируст халдварын тохиолдлыг тусгаарлах, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, илрүүлэг, эрэмбэлэн ангилалт хийх үйл ажиллагаанд энэхүү зааврыг баримтлана.

1.2. Эрүүл мэндийн байгууллагад хүчин төгөлдөр хэрэгжиж буй халдварын сэргийлэлт, хяналт, эмнэлгийн гаралтай аюултай хог хаягдлын менежментийн журам, зааврыг мөрдөж ажиллана.

1.3. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа хүн бүрийг эрсдэлтэйд тооцон тусламж үйлчилгээний төрөл, хэлбэрээс үл хамааран эмнэлгийн бүх ажиллагсад амны хаалт зүүж, гарын эрүүл ахуйг сахина. Шингэн цацагдах, үсрэх эрсдэлтэй үед нүүрний хаалт, эмнэлгийн нэг удаагийн халадыг хэрэглэж эмнэлэг бүр халдвараас сэргийлэх стандарт дэглэмийг мөрдөнө.

Хоёр. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөнийг хэвтүүлэн эмчлэх эмнэлэг, тусгаарлах байрны зохион байгуулалт

2.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдлыг эмнэлэгт, тархалтын түвшингээс хамаарч хавьтлыг тусгаарлан ажиглах байр эсхүл гэрт нь тусгаарлана.

2.2. Эмнэлгийн орны ачаалал ихэсч, тусгаарлах эмнэлэг хүрэлцээгүй болсон үед нэмэлтээр эмнэлэг дэлгэнэ.

2.3. Эмнэлзүйн шинж тэмдэггүй, хөнгөн хэлбэрээр өвдсөн иргэдийг гэрээр тусгаарлан эмчилж болно.

2.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлыг тусгаарлах эмнэлэг, байгууламжийг халдвартай буюу улаан, халдварын эрсдэл дунд буюу шар, халдваргүй буюу ногоон гэсэн 3 бүсэд хувааж, тусгаарлалтыг зохион байгуулна. Доорх бүсүүд нь хоорондоо бүрэн тусгаарлагдсан байна.

2.4.1. Халдвартай улаан бүс: халдварын сэжигтэй, магадлалтай, батлагдсан өвчтний хэвтэн эмчлүүлэх хэсэг;

2.4.2. Шар бүс: халдвартай бүсэд ажилласан эрүүл мэндийн ажилтны хамгаалах хувцас тайлах хэсэг байна. Тус хэсэгт 50 литрээс дээш хэмжээтэй (өргөн 50 см, урт нь 80 см дээш байх) том амсартай хог хаягдал цуглуулах уут бүхий хогийн сав, гар халдваргүйжүүлэх бодис, гутал халдваргүйжүүлэх уусмал болон урт бариултай губка, нүдний шил халдваргүйжүүлэх бодис зэргийг бэлтгэсэн байна.

2.4.3. Халдваргүй ногоон бүс: эмнэлгийн ажилтны байрлах өрөө, эмнэлгийн бусад хэсгийг хамруулна.

2.5. Тусгаарлах эмнэлэгт өвчтөн хүлээн авах хаалга, эмнэлгийн ажилтны орох, гарах хаалга тусдаа байхаар зохион байгуулна. Тусгаарлах эмнэлгийн өвчтөний өрөө нь агааржуулалт сайтай байх ба механик агааржуулалттай, байгалийн агааржуулалттай бол салхивч нь нээгддэг байна.

2.6. Сэжигтэй тохиолдлыг шинжилгээний хариу гартал нэг, нэгээр тусгаарлана. Хэрэв нэгээс дээш хүнийг нэг өрөөнд тусгаарлах бол ор хоорондын зай 1.5-2 метрээс дээш байх ба ор хооронд тусгаарлагч ашиглана.

2.7. Батлагдсан тохиолдлыг нэг оронд оногдох талбайн хэмжээ 8м²-аас багагүй байхаар тооцож хамтад нь тусгаарлаж болно.

2.8. Шинээр оношлогдсон өвчтөнийг эмчилгээ, тусгаарлалтын хугацаа дуусч байгаа хүнтэй хамт нэг өрөөнд тусгаарлахгүй.

2.9. Тусгаарлах өрөө нь дотроо гарын угаалтуур, суултууртай байна. Өрөө нь дотроо ариун цэврийн өрөөгүй нийтийн ариун цэврийн өрөө ашиглаж байгаа үед коридорыг улаан бүсэд тооцож зохион байгуулалтыг хийнэ.

2.10. Хөдөө, орон нутагт биосуултуур, гоожуурт угаагуур, жорлон ашиглаж болно. Эмнэлгийн ажилтаны хэрэглэх жорлон, угаагуур тусдаа байна.

Гурав. Тусгаарлах эмнэлэгт мөрдөх халдвараас сэргийлэх арга хэмжээ

3.1. Халдвартай бүсэд мөрдөх халдвараас сэргийлэх арга хэмжээ

3.1.1. Ажилтан улаан бүсэд орох давтамж, ажиллах хугацааг аль болох бага байлгахгаар тооцож, үйл ажиллагааг зохион байгуулна.

3.1.2. Батлагдсан болон сэжигтэй тохиолдолд тусламж үзүүлэх ажилтаныг тус тусад нь томилно. Хэрэв нэг ажилтан ажиллаж байгаа бол сэжигтэй тохиолдолд тусламж үйлчилгээг эхэлж үзүүлсэний дараа батлагдсан тохиолдолд тусламж үйлчилгээг үзүүлнэ. Тохиолдол хооронд бээлий солино.

3.1.3. Үйлчлүүлэгчийн өрөөнд халдваргүйжүүлэлт хийхдээ өвчтөн болон орчны эд зүйлд хүрэлцэж хувцсаа бохирдуулахаас сэргийлж, зай барина.

3.1.4. Хамгаалах хувцас, хэрэгслийг Хүснэгт 2-т заасны дагуу зөв, зүй зохистой хэрэглэнэ.

3.1.5. Халдвартай бүсэд байгаа мэдээллийг цахимаар авах боломж (дата, таблет, гар утас, бусад тоног төхөөрөмж)-оор хангана. Эрүүл мэндийн ажилтнууд халдвартай бүсэд өөрсдийн гар утсыг авч орохгүй, авч орохоор бол гялгар уутанд хийж авч орно.

3.1.6. Халдвар дамжуулах эрсдэл багатай даралтны аппарат, чагнуур, халууны шил, пульсоксиметр зэрэг багаж хэрэгслийг үйлчлүүлэгч хооронд 70 хувийн спирт эсхүл зориулалтын халдваргүйжүүлэх бодистой салфеткаар арчиж халдваргүйжүүлнэ.

3.1.7. Өвчтөний өрөөний агаар сэлгэлтийг тогтмол, боломжгүй бол 2 цаг тутам 10-15 минут хийх ба өрөөний хаалгыг хаалттай байлгана.

3.1.8. Тусгаарлалтад байгаа үйлчлүүлэгчийг өрөөнөөс гарах, бусад хүмүүстэй уулзахыг хориглоно.

3.1.9. Тусгаарлалтад байгаа үйлчлүүлэгчийн эд зүйлсийг өрөөнөөс гаргахгүй. Зайлшгүй шаардлагатай хэрэгцээний эд зүйлсийг гаднаас оруулж болно.

3.1.10. Үйлчлүүлэгчийн өрөөнд орох эмнэлгийн ажилтан (инженер, техникийн ажилчин, сантехникийн слесарь), ар гэр, сахиур зэрэг хүний тоог хязгаарлаж, орж, гарсан хүмүүсийн бүртгэлийг хөтөлнө. Өвчтөний өрөөнд (улаан бүс) орсон ажилтны бүртгэлийг хөтөлнө.

3.1.11. Зайлшгүй шаардлагаар түр хугацаагаар өвчтөний өрөөнд орсон гэр бүлийн гишүүд, бусад хүмүүст хамгаалах хувцас өмсгөнө. Хамгаалах хувцсыг эрүүл мэндийн ажилтны хяналтан дор тайлна.

3.1.12. Тусгаарлах эмнэлэгт зөөврийн рентген, хэт авианы оношилгоо хийх аппарат, тоног төхөөрөмж байршуулсан байна. Байхгүй үед гаднаас орсон тохиолдолд гадаргууг шар бүсэд халдваргүйжүүлнэ.

3.2. Хувцас тайлах хэсэг буюу шар бүсэд мөрдөж ажиллах халдвараас сэргийлэх арга хэмжээ

3.2.1. Хамгаалах хувцас, хэрэгсэл өмсөхгүйгээр улаан болон шар бүсэд орохыг хатуу хориглоно.

3.2.2. Хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу тайлж гараа халдваргүйжүүлнэ.

3.2.3. Хувцас тайлах хэсгийг камержуулна.

3.2.4. Хувцас тайлах дарааллыг харуулсан зурагт хуудас, бие бүрэн харагдах толь байршуулна.

3.2.5. Ажилтан хувцас тайлахдаа дараалал, санамжийг нэг бүрчлэн харж, толинд шалгаж тайлна.

3.2.6. Нэг удаагийн үзлэгийн бээлийг ажил дууссаны дараа халдваргүйжүүлэхгүй шууд тайлж, хаях бөгөөд зөвхөн ахуйн бээлийг халдваргүйжүүлнэ.

3.2.7. Халдвартай бүсэд өмссөн гутлаа шар бүсэд тайлж үлдээгээд ногоон бүс рүү цэвэр гутлаа өмсөж орно. Өмсөх гутлыг шар бүсийн гадна үүдэнд бэлтгэж тавьсан байна.

3.2.8. Хувцас тайлах хэсэгт гар халдваргүйжүүлэх бодис нь мэдрэгчтэй эсхүл тохойгоор ажилладаг савтай байна.

3.2.9. Хувцас тайлах хэсэгт үлдээсэн гутал, давтан ашиглагдаж байгаа хэрэгслийг ариутгалын ажилтан эсхүл үйлчлэгч цэвэрлэж, халдваргүйжүүлээд ногоон бүс рүү гаргана.

3.2.10. Шар бүс дэх хог хаягдлыг ариутгалын ажилтан эсхүл үйлчлэгч улаан бүсээр гаргаж, шар бүсэд халдваргүйжүүлэлтийг хийгээд хамгаалах хувцсаа тайлна.

3.2.11. Шар бүсэд цэвэрлэгээний ус, халдваргүйжүүлэх уусмалыг зайлуулах бохир усны шугам хоолой байхгүй үед улаан бүс рүү оруулж асгана.

3.3. Халдваргүй бүсэд мөрдөж ажиллах халдвараас сэргийлэх арга хэмжээ

3.3.1. Эмнэлгийн ажилчдыг аль болох нэг нэгээр байлгана. Өрөө нь агааржуулалт хийх боломжтой байна.

3.3.2. Өрөө хооронд сэлгүүцэхгүй, хамт сууж хоол унд идэхгүй, хүн бүр өөрийн аяга, тавга зэрэг хоолны хэрэгсэлтэй байна.

3.3.3. Цаасан материалыг халдваргүй бүсэд сувилагчийн постон дээр хөтөлнө. Амрах өрөөнд оруулж хөтлөхийг хориглоно.

3.3.4. Халдвартай бүсэд хэрэглэсэн эд зүйл, цаасан материалыг халдваргүй бүсэд оруулахыг хориглоно.

3.3.5. Эмнэлгийн ажиллагсадын байрлах хэсэгт усанд орох болон хувцас угаах, индүүдэх нөхцлийг бүрдүүлсэн байна.

3.3.6. Ус буцалгагч, хоол халаах цахилгаан зуух, хөргөгчтэй байна.

3.3.7. Эмнэлгийн өмд, цамц, гутал 2-оос доошгүй эзлжтэй байх, хамгаалах хувцасны дотор өмссөн өмд цамцыг халдваргүй бүсэд ороод сольж өмсөх өмд, цамц, гутал тусдаа байна.

3.3.8. Багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгахад Эрүүл мэндийн сайдын 2019 оны 537 дугаар тушаалын 2 дугаар хавсралтыг мөрдөнө.

3.4. Тусгаарлах эмнэлэг, коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөнд тусламж үзүүлж байгаа эрүүл мэндийн болон эрүүл мэндийн бус байгууллагад өдөр тутмын болон голомтын эцсийн халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээ хийхдээ Эрүүл мэндийн сайдын 2019 оны 537 дугаар тушаал дахь "Эрүүл мэндийн байгууллагад цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх заавар"-ыг мөрдөнө.

3.5. Үйлчлүүлэгчийн хэрэглэсэн цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийг цэвэрлэж, халдваргүйжүүлэхэд Эрүүл мэндийн сайдын 2019 оны 537 дугаар тушаалын 8 дугаар хавсралтаар батлагдсан зааврыг баримтална.

3.6. Хог хаягдлыг цуглуулах, зөөх, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаанд Эрүүл мэндийн сайдын 2017 оны 505 дугаар тушаалыг мөрдөнө.

Дөрөв. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөнг эмнэлгийн бус орчинд эмчлэх, хянах үед мөрдөх халдвараас сэргийлэх арга хэмжээ

4.1. Агааржуулалт сайтай өрөөнд гэр бүлийн гишүүдээс аль болох тусдаа байж, цонх хаалгаа нээж агааржуулалт тогтмол хийнэ. Тусдаа өрөөнд байх боломжгүй бол 1.5-2 метрийн зай барина.

4.2. Гэрээр асрах, сувилах хүний тоог хязгаарлаж, гэртээ зочин хүлээж авахгүй байна.

4.3. Эрүүл мэндийн ажилтан эсхүл асарч, сувилж байгаа хүн өвчтөн болон түүний орчинтой ямар нэг байдлаар харьцсан бол амны хаалттай байх ба гараа савандаж угаана эсхүл гар халдваргүйжүүлэх уусмал ашиглана.

4.4. Үзлэг, тусламж үйлчилгээний үед өвчтөнд эмнэлгийн амны хаалт зүүлгэнэ. Ханиах, найтаах үед ам, хамрыг бүрэн дарах сальфетка, алчуур хэрэглүүлнэ.

4.5. Эрүүл мэндийн ажилтан амны хаалт зүүж, хамгаалах хувцас өмсөнө. Гэр бүлийн гишүүд амны хаалт зүүнэ.

4.6. Биологийн шингэн, ялангуяа амны хөндийн болон амьсгалын замын шүүрэл, өтгөнтэй шууд харьцахаас зайлсхийх. Харьцах бол амны хаалт, бээлий хэрэглэнэ.

4.7. Өвчтөнд зориулсан тусдаа гарын алчуур, цагаан хэрэгсэл, даавуу, сав суулга хэрэглэнэ. Эдгээр зүйлсийг савантай усаар угаан цэвэрлэж, дахин хэрэглэж болно.

4.8. Өвчтөний өрөөний ширээ, ор, хаалганы бариул, тавилга зэрэг байнга хүрдэг хэсгийн гадаргууг өдөр бүр саван эсхүл угаалгын бодисоор цэвэрлэнэ.

4.9. Ариун цэврийн өрөөний гадаргууг өдөрт нэг удаа цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

4.10. Бохирлогдсон угаах зүйлсийг сэгсрэхгүй, арьс болон хувцсандаа хүргэхгүй. Өвчтөний хувцас, орны даавуу, ванны болон гар нүүрний алчуурыг 60-90°C-тэй усанд савандаж, эсхүл угаалгын нунтаг хэрэглэж угаана.

4.11. Биеийн шингэнээр бохирлогдсон даавуун эдлэл болон хувцсыг сэгсрэхгүй, зөөлөн ороон авч, цэвэрлэхдээ бээлий болон хамгаалах хувцас өмсөнө. Резинэн (ахуйн) бээлийг хэрэглэсний дараа савантай усаар цэвэрлээд 0.1% натрийн гипохлоритын уусмалаар халдваргүйжүүлнэ.

4.12. Хамгаалах хувцас хэрэгслийг хийх халдвартай хог хаягдлын ууттай байна.

Тав. Аэрозол үүсгэх ажилбарын үеийн халдвараас сэргийлэх арга хэмжээ

5.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдолд дараах ажилбаруудыг хийх үед аэрозол хэлбэрээр халдвар дамжих эрсдэлтэй.

5.1.1. Бронх дурандах;

5.1.2. Интубаци тавих, авах;

5.1.3. Амьсгал, зүрхний сэхээн амьдруулах тусламж үзүүлэх (CPR);

5.1.4. Зохиомол амьсгал (маск, интубаци);

5.1.5. Соруулга хийх;

5.1.6. Утлага эмчилгээ

5.1.7. Амьсгалын замд хийгдэх мэс засал;

5.1.8. Шүдний эмчилгээ, өрөм, борын машин ажиллуулан тусламж үзүүлэх

5.2. Аэрозол үүсгэх ажилбар хийх өрөө нь агаарын сөрөг даралттай эсхүл механик агааржуулах системтэй, салхивчаар агаар сэлгэлт хийх боломжтой байна. Хэрэв механик агааржуулах систем ашиглаж байгаа тохиолдолд агаар солилцох давтамж нь нэг цагт 12-оос багагүй байна.

5.3. Ажилбарын үед өрөөнд байх хүний тоог хамгийн бага хэмжээнд байлгана.

5.4. Ажилбар дууссаны дараа өрөөнд агаар сэлгэлт хийж, цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

5.5. Аэрозол үүсгэх ажилбар гүйцэтгэх эрүүл мэндийн ажилтан иж бүрэн хамгаалах хувцас өмсөж, эмнэлгийн зориулалтын 95 хувь буюу түүнээс дээш шүүлтүүртэй (N95, FFP2, FFP3) амны хаалт хэрэглэнэ.

Зургаа. Өвчтөнг шилжүүлэх, тээвэрлэх үеийн халдвараас сэргийлэх арга хэмжээ

6.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлыг өөр эмнэлэгт шилжүүлэх, зөөвөрлөх асуудлыг тандалтын баг болон эмнэлзүй, халдварын сэргийлэлт, хяналтын баг зөвшилцөн шийдвэрлэнэ.

6.2. Зайлшгүй шаардлагатай оношилгоо, эмчилгээ хийх зорилгоор өвчтөнг эмнэлгийн бусад тасаг, хэсэг, өөр эмнэлэг рүү шилжүүлэх бол очих зам талбайг урьдчилан чөлөөлүүлж, бусад хүмүүстэй хавьтал болохоос сэргийлнэ.

6.3. Өвчтөнг шилжүүлэх, тээвэрлэх үед амны хаалт тогтмол зүүлгэнэ. Эрүүл мэндийн ажилтан улиралд тохирсон болон хамгаалах хувцас өмсөнө.

6.4. Автомашинаар тээвэрлэх үед үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлэх шаардлагагүй бол эмч, эрүүл мэндийн ажилтан жолоочийн бүхээгт сууна.

6.5. Коронавируст халдвартай болон халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг зөөх тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангана.

6.6. Жолооч, эмчийн урд кабин хэсэг, зорчигчийн хэсгээс бүрэн тусгаарлагдсан байна.

6.7. Тээвэрлэх явцад цонх нээж агаар сэлгэлт хийх ба машины агааржуулах төхөөрөмж (air condition)-ийг ажиллуулахгүй. Гаднах агаараас сэлгэх (дотор агаараар сэлгэлтийг хориглох) сорох, хүйтэнд паар асаахдаа гадна агаараас сэлгэх горимыг сонгон ажиллуулна.

6.8. Түргэн тусламжийн машинд хүчилтөрөгчийн хангамж, маск, амбу, интубаци тавих хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгсэл, гар халдваргүйжүүлэгч, дамнуурга, хогийн сав, цэвэрлэгээний материал, халдваргүйжүүлэх бодис гэх мэт яаралтай тусламж үзүүлэх болон халдвараас сэргийлэх хэрэгслийг бэлэн байлгана.

6.9. Автомашины аюулгүй байдлыг хангах, хурд тохируулахын зэрэгцээ дотроос холбоо барих боломжтой харилцаа холбооны хэрэгсэл, гар утастай байна.

6.10. Автомашиныг ашигласан тохиолдол бүрт гар хүрэлцэх хэсгүүдийг арчиж халдваргүйжүүлнэ.

6.11. Бөөлжис, цэр, цус зэрэг биологийн шингэнээр бохирлогдсон бол халдваргүйтгэн цэвэрлэнэ.

6.12. Автомашины кабиныг цэвэрлэсний дараа гар хүрэлцдэг хэсгүүдийг арчиж, өвчтөн хүрэлцээгүй бусад хэсэгт мананцар үүсгэгч, шүршигч ашиглан халдваргүйжүүлнэ. Мананцар үүсгэгч ашиглаж байгаа үед хаалга, цонхыг хааж, дотор талд хүн байхгүй нөхцөлд хийнэ. 2 цагийн дараа цэвэрлэгээ хийнэ.

Долоо. Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх

7.1. Тусгаарлах эмнэлэг, ажиглалтын байр, илрүүлэг, эрэмбэлэн ангилалт хийх нэгжүүдэд ажиллах ажилтан сургаж, бэлтгэгдсэн байна.

7.2. Коронавируст халдвар (КОВИД-19) –ын тархалтын түвшин улбар шар, улаан буюу халдвар голомтлон эсхүл хүн амын дунд өргөн тархсан орон нутагт тусгаарлах эмнэлэгт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанг ажлын цагийн хэвийн горимоор ажиллуулна. Тусламж үйлчилгээ үзүүлэхдээ халдвараас сэргийлэх дэглэм баримтлан ажиллаж, ажил дууссаны дараа хувцас хэрэгслээ бүрэн сольж, усанд орон халдвараас сэргийлэх арга хэмжээг мөрдөн ажиллана.

7.3. Батлагдсан тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлж буй эмнэлгийн мэргэжилтнүүдийг дархлаа тогтоцыг тодорхойлох эсрэгбие илрүүлэх шинжилгээнд 6 сар тутам хамруулна.

7.4. Халдварын сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдлоос тархварзүйн асуумж авахдаа тусгаарлах өрөөнд оруулахгүйгээр дотуур утас, гар утас, камер, дуудлагын систем ашиглаж авна.

Найм. Эрүүл мэндийн ажилтанг халдвараас сэргийлэхэд эмнэлгийн чанар, халдварын сэргийлэлт, хяналт, сувилахуйн албаны гүйцэтгэх үүрэг

8.1. Ажилтаныг халдварт өртөхөөс сэргийлэх, сургах, бэлтгэх, шаардлагатай хэрэгслээр хангахад байгууллагын удирдлага, санхүү, аж ахуй, эмнэлгийн тусламжийн чанар, халдварын сэргийлэлт хяналт, хүний нөөц, сувилахуй, дотоод хяналтын албад хамтран ажиллана.

8.2. Хамгаалах хувцас, хэрэгслийг зөв өмсөх, аюулгүй тайлах, гарын эрүүл ахуй сахих, халдваргүйжүүлэх бодисыг зөв хэрэглэх, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх зэрэг халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр эрүүл мэндийн ажилтныг тогтмол сургана.

8.3. Ажилтныг тусгаарлалтад орохоос өмнө хамгаалах хувцас өмсөх, тайлах, гар угаах, халдваргүйжүүлэх дадлыг хүн тус бүрээр нэг бүрчлэн шалгаж дадал олгосон байна.

8.4. Халдвараас сэргийлэх зааврыг хэрэгжүүлэн, мөрдөж ажиллах, хүн бүрийн хариуцлагын талаар ажилтнуудад анхааруулга өгч баримтжуулсан байна.

8.5. Тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад санамсаргүйгээр халдварт өртөх эрсдэл үүссэн тохиолдолд (хамгаалах хувцас өмсөөгүй, буруу өмссөн, хувцас урагдсан, гэмтсэн, биологийн шингэнд хамгаалалтгүй хүрсэн зэрэг) эмнэлгийн халдварын сэргийлэлт хяналт (ХСХ)-ын багт нэн даруй мэдэгдэнэ.

8.6. Хувцас өмсөх, тайлах, гарын эрүүл ахуй сахих, цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг шалгах хуудсаар өдөр бүр хянах, хянаж байгаа эсэхэд ХСХ, чанар, сувилахуйн алба хяналт тавьж ажиллана.

Ес. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагад хэрэгжүүлэх халдвараас сэргийлэх арга хэмжээ

9.1. Утсаар болон цахимаар холбогдож зөвлөгөө, заавар өгөх үйлчилгээ зохион байгуулна.

9.2. Халдварын шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчдэд тусламж үзүүлэх тусгаарлах хэсгийг, үндсэн тусламж үйлчилгээ үзүүлэх хэсгээс тусад нь зохион байгуулна.

9.3. Халуунтай болон халдварын шинж тэмдэгтэй үйлчлүүлэгчийг эмнэлэгт ирэхгүй байх, утсаар холбогдох заавар зөвлөмж авах талаар иргэдэд мэдээлэл өгнө.

9.4. Хөтөч ажилтан, дуугүй хөтөчийг ажиллуулж, халуунтай болон халдварын шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчийг тусгаарлах өрөө рүү чиглүүлэн, бусад үйлчлүүлэгчтэй хавьтал болохоос сэргийлнэ.

9.5. Үйлчлүүлэгчдэд амны хаалт зүүх, гарын эрүүл ахуй сахих, зөв ханиаж, найтаах санамж, анхааруулгыг өгнө.

9.6. Үзлэгийн өрөө бүрт амны хаалт, гар халдваргүйжүүлэх бодис байрлуулсан байна.

9.7. Үзлэг, оношилгооны явцад халдварын сэжигтэй тохиолдол илэрвэл үйлчлүүлэгчид амны хаалт зүүлгэж, өрөөнөөс гаргахгүй, өрөөнд нэмж хүн оруулахгүй ба яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэхээс бусад тохиолдолд 1,5-2 метрээс дотогш зайд ойртохгүй байна.

9.8. Эрүүл мэндийн ажилтан тусламж, үйлчилгээ үзүүлэхэд амны хаалтыг тогтмол хэрэглэнэ.

9.9. Үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилтны дунд коронавируст халдварын шинж тэмдгийн тандалтыг өдөр бүр хийнэ.

9.10. Хэвтэн эмчлүүлэгчдээс халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед тусгаарлах өрөөнд шилжүүлэн, лабораторийн шинжилгээнд сорьц авч, шинжилгээний хариу гартал эмчилгээг үргэлжлүүлнэ.

9.11. Халдварын сэжигтэй, батлагдсан тохиолдлыг шилжүүлэх боломжгүй, нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд тухайн эмнэлгийн тусгаарлах өрөөнд тусгаарлаж эмчилнэ. Тусламж үзүүлэх ажилтан, багийг тусад нь томилон ажиллуулна.

9.12. Нэг өрөөнд хамт байсан үйлчлүүлэгч болон бусад хавьтлуудыг бүртгэж, тусгаарлан ажиглалтад авна.

Арав. Өвчтөнд тусламж үзүүлэх үед хэрэглэх хамгаалах хувцас, хэрэгсэл

10.1. Хамгаалах хувцас, хэрэгсэл нь шингэн нэвчихгүй, чөлөөтэй хөдлөх боломжтой, биеийн хэмжээнд тохирсон байна.

10.2. Хамгаалах хувцас хэрэгслийг давхарлаж өмсөхгүй байх, тусламж, үйлчилгээг аль болох богино хугацаанд (1 өвчтөнд 15) минут үзүүлнэ.

10.3. Ижил оношоор тусгаарлагдсан бүх үйлчлүүлэгчдэд нэг хамгаалах хувцастайгаа тусламж, үйлчилгээ үзүүлж дуусгана. Үйлчлүүлэгч болон өрөө хооронд хамгаалах хувцсыг дахин солих шаардлагагүй

10.4. Тусламж үйлчилгээ үзүүлэх үедээ өвчтөнд хүрсэн бол бээлийг үйлчлүүлэгч хооронд солино.

10.5. Шүүлтүүртэй амны хаалтны дотор нэг удаагийн амны хаалтыг давхарлаж зүүхгүй.

10.6. Хамгаалах хувцас илт бохирдоогүй, нороогүй, урагдаж цоороогүй, бол 4 цаг хүртэл хугацаагаар хэрэглэж болно.

10.7. Батлагдсан тохиолдлыг зөөвөрлөх машины бүхээг хэсэг бүрэн тусгаарлагдсан, өвчтөнийг суух, буух зэрэгт туслалцаа үзүүлэх шаардлагагүй, 1,5-2 метрээс дотогш зайд харьцахгүй үед жолооч нэг удаагийн амны хаалт, ажлын хувцасны гадуур халад өмсөнө. Ажлын байранд өмссөн хувцсыг гэртээ болон, амралтын өрөө зэрэг ажлын бус орчинд өмсөхгүй, ажил дууссаны дараа солих ба хувцасыг гэртээ авч явахгүй байна.

10.8. Автомашины бүхээгийн хэсэг тусгаарлагдаагүй, дамнуурга ашиглах, өвчтөнийг буух, суухад туслах зэргээр өвчтөнтэй 1,5-2 метрээс дотогш зайд харьцах эрсдэлтэй бол жолооч хамгаалах хувцас өмсөнө.

10.9. Эмч тусламж үйлчилгээ үзүүлэх, өвчтөнтэй харьцах үед хамгаалах хувцас өмсөнө.

10.10. Өвчтөнийг хүлээн авсан эрүүл мэндийн байгууллага тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлт цэвэрлэгээг хийнэ. Хүргэж ирсэн эмч, жолоочийн хамгаалах хувцас хэрэгслээ тайлах газрыг бэлтгэж, гар угаах, хувцас солих нөхцлийг бүрдүүлсэн байна.

10.11. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед эрүүл мэндийн ажилтан хүснэгт 3-т заасан хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөнө.

10.12. Эрүүл мэндийн бус байгууллагын ажилтан хүснэгт 4-т заасан хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөнө.

Хүснэгт 3. Эрүүл мэндийн ажилтны хамгаалах хувцас, хэрэгсэл

№	XXX-ийн нэр	Хийх ажилбар
1	1. Шүүлтүүртэй амны хаалт (N95 эсхүл FFP2) 2. Комбинзон 3. Бээлий 4. Нүдний шил эсхүл нүүрний хаалт 5. Малгай 6. Гутлын гадуур улавч	Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнд дараах аэрозол үүсгэх ажилбар хийх үед: 1. Бронх дурандах; 2. Интубаци тавих, авах; 3. Амьсгал, зүрхний сэхээн амьдруулах тусламж үзүүлэх (CPR); 4. Зохиомол амьсгал (маск, интубаци); 5. Соруулга хийх; 6. Амьсгалын замд хийгдэх мэс засал; 7. Шүдний эмчилгээ, өрөм, борын машин ажиллуулан тусламж үзүүлэх 8. Молекул биологийн лабораторийн улаан бүсэд SARS-CoV-2 илрүүлэх бх-ПГУ шинжилгээ
2	1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт 2. Шингэн нэвчихгүй ариун халад 3. Малгай 4. Ариун бээлий 5. Нүдний шил эсхүл нүүрний хаалт 6. Гутлын гадуурх улавч 7. Шингэн нэвчих эрсдэлтэй бол нэг удаагийн хормогч	Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнд амьсгалын замаас бусад мэс заслын тусламж Ариун нөхцөлд хийгдэх ажилбар
		Коронавируст халдвар (КОВИД-19)-тай эхийн төрөлт удирдах, эх барихын тусламж үйлчилгээ
3	1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт 2. Халад 3. Малгай 4. Бээлий 4. Нүдний шил эсхүл нүүрний хаалт 5. Гутлын гадуурх улавч	1. Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнд үзүүлэх бусад үзлэг, эмчилгээ, оношлох 2. Хамар залгиураас сорьц авах
		Кабин тусгаарлагдаагүй нөхцөлд батлагдсан, сэжигтэй тохиолдлыг зөөх, тээвэрлэх
4	1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт 2. Халад 3. Малгай 4. Бээлий 5. Ахуйн бээлий 6. Нүдний шил эсхүл нүүрний хаалт 7. Усны гутал	Үйлчилгээний болон ариутгалын ажилтан коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөний өрөөг цэвэрлэх, халдваргүйжүүлэх
		Багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх
		Хог хаягдлыг зөөх, тээвэрлэх
5	1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт 2. Халад 3. Нүүрний хаалт (Эрсдэлд үндэслэн хэрэглэнэ)	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан, сэжигтэй тохиолдлыг тээвэрлэхэд жолооч өвчтөнд хүрэхгүй, кабинд тусгаарлагдсан үед Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа бүх ажилтан
6	Амны хаалт	Эрүүл мэндийн байгууллагын захиргаа, аж ахуйн ажилтан

**Хүснэгт 4. Эрүүл мэндийн бус байгууллагын ажилтны
хамгаалах хувцас хэрэгсэл**

№	ХХХ-ийн нэр	Хийх үйл ажиллагаа
1	1. Амны хаалт 2. Халад 3. Нүдний шил эсхүл нүүрний хаалт 4. Бээлий 5. Малгай 6. Усны гутал эсхүл гутлын гадуурх улавч	– Тусгаарлан ажиглах байранд ажиллах эрүүл мэндийн ажилтан – Хилийн мэргэжлийн хяналтын байцаагч – Агаарын хөлгийн үйлчлэгч
2	1. Амны хаалт 2. Нүдний шил 3. Бээлий	– Ачаа ачигч, буулгагч – Инженер техникийн болон бусад ажилтан
3	1. Амны хаалт 2. Халад 3. Нүдний шил эсхүл нүүрний хаалт 4. Үзлэгийн бээлий 5. Малгай 6. Усны гутал эсхүл гутлын гадуурх улавч	Тусгаарлан ажиглах байранд халдварын шинж тэмдэг илэрсэн хүнд тусламж үзүүлэх эрүүл мэндийн ажилтан
		Тусгаарлан ажиглах байранд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх ажилтан
		Хилийн нэвтрэх цэгт ажиллаж байгаа халдваргүйжүүлэлт хийх ажилтан
4	Амны хаалт	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтот бүс нутгаас ирсэн ачаа тээштэй харьцах үед
		Агаарын хөлгийн нисгэгч, галт тэрэгний машинист нь үйлчлүүлэгчтэй харьцахгүй бүрэн тусгаарлагдсан нөхцөлд ажиллаж байгаа тохиолдолд
		Ажиглалтын байранд үйлчлүүлэгчтэй шууд харьцахгүйгээр хоол болон зргэлтийн зүйлсийг түгээх үед
		Тусгаарлах хаалтны цаанаас харьцаж байгаа үйлчилгээний ажиллагсад
		Цагдаа, онцгой байдлын ажилтан, гал тогооны ажилтнууд үйлчлүүлэгчтэй шууд харьцаагүй тохиолдолд

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЛАБОРАТОРИЙН ОНОШИЛГООНЫ ТҮР ЗААВАР

Нэг. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй гэж оношилсон тохиолдлоос сорьц авах, хадгалах, тээвэрлэх

1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй, магадлалтай тохиолдлоос сургагдсан эрүүл мэндийн ажилтан эмчилгээ эхлэхээс өмнө хамрын хөндийн арчдас, хамар-залгиурын арчдас, ам-залгиурын арчдас, амьсгалын доод замын хүнд хэлбэрийн өвчтэй бол цэр, амьсгалын гуурстай бол мөгөөрсөн хоолойн сордос, мөгөөрсөн хоолой-альвеолын лаваж авна. Нэмэлтээр цус, шээс, өтгөн, шаардлагатай бол уушигны эд, эсийн сорьц авч шинжилнэ.

1.2. 4-11 насны хүүхдээс ам-залгиур, 11-ээс дээш насны хүнээс хамар залгиурын арчдас авна.

1.3. Сорьц авах үед өрөөнд байх хүний тоог аль болох цөөлж, зөвхөн өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн ажилтнуудыг байлцуулна.

1.4. Шинжлэгдэхүүн авах эрүүл мэндийн ажилтан нь хамгаалах хувцас, хэрэгслийг бүрэн өмсч, ХЕПА шүүлтүүр бүхий N95 амны хаалт, нүдний шил эсвэл нүүрний халхавч зүүнэ.

Хоёр. Сорьц цуглуулахад шаардагдах зүйлс

- 2.1. Шингэн үл нэвтрүүлэх материалаар хийгдсэн халад
- 2.2. N95 амны хаалт
- 2.3. Нүдний хамгаалалт (нүдний шил буюу нүүрний халхавч)
- 2.4. Эмнэлгийн бээлий
- 2.5. 7-8 см урт уян эсхүл иштэй ариун бамбар
- 2.6. Хэл дарагч
- 2.7. 2-4 мл вирус зөөвөрлөх орчин эсхүл 0.9% натри хлорид бүхий бөглөөтэй хуруу шил
- 2.8. Хуруу шил тогтоогуур
- 2.9. Цэрний сав
- 2.10. Сорьц зөөвөрлөх зориулалтын сав
- 2.11. Сорьц дагалдах хуудас
- 2.12. Шилний маркер

Гурав. Лабораторийн шинжилгээнд сорьц авах

3.1. Хамрын хөндийн арчдас авах: Сорьц өгөх хүний нусыг нийлгэх буюу ариутгасан бамбараар хамрын хөндийг арчиж цэвэрлүүлэн суугаа байрлалд толгойг 70 хэм гэдийлгэн сорьцыг авна. Хүүхдээс сорьц авах тохиолдолд асран хамгаалагчид хүүхдийг тэврүүлж суулгана. Зүүн гарын эрхий, долоовор хуруугаар тухайн хүний хамрын үзүүрээс чимхэж, баруун гартаа ариун бамбар барьж, болгоомжтой зөөлөн эргүүлэх хөдөлгөөнөөр хамрын хөндийн самалдаг руу насанд хүрэгч бол 3 см, хүүхэд бол 2 см оруулан, бамбараа салст бүрхүүл рүү шахаж

эргүүлэн арчдас авч, зориулалтын вирус тээвэрлэх уусмал эсхүл 0.9% натри хлорид бүхий хуруу шилэнд хийнэ.

3.2. Хамар-залгиурын арчдас авах: Тухайн хүнийг дээрх байдлаар бэлтгэж, ариун бамбарыг болгоомжтой зөөлөн эргүүлэх хөдөлгөөнөөр хамрын хөндийн самалдаг руу насанд хүрэгч бол 4-5 см, хүүхэд бол 2-3 см оруулан, бамбараа салст бүрхүүл рүү шахаж эргүүлэн арчдас авч, зориулалтын вирус тээвэрлэх уусмал эсхүл 0.9% натри хлорид бүхий хуруу шилэнд хийнэ.

3.3. Ам-залгиурын арчдас авах: Тухайн хүнийг дээрх байдлаар бэлтгэж, суулгаад амыг ангайлгаж, хэл дарагчаар хэлийг дарж, залгиурын арын ханыг хатуу иштэй ариун бамбараар арчиж авна. Арчдасыг зориулалтын вирус тээвэрлэх уусмал бүхий хуруу шилэнд хийнэ.

3.4. Цэр авах:

3.4.1. Амыг усаар сайтар зайлуулж, амны хөндийг цэвэрлэн, хамар ба хоолойн салс, шүлс зэргийг аль болох оруулахгүй авна.

3.4.2. Амьсгалыг гүнзгий авахуулан, түгжин 2 секунд орчим болсны дараа аажим гаргуулж, 2-оос доошгүй удаа давтана.

3.4.3. Гурав дахь удаагаа амьсгалыг гүнзгий авахуулж, хүчтэй ханиалгуулан цээжний гүнээс цэрийг гаргуулна.

3.4.4. Гаргасан цэрийг цэр цуглуулах саванд хийнэ. Цэрний хэмжээ 3-5 мл байна.

3.4.5. Цэрийг агааржуулалт сайтай, зориулалтын өрөөнд эсхүл гадна орчинд авна.

3.5. Шүлс авах:

3.5.1. Шүлс цуглуулах зориулалтын савыг онгойлгож бэлдэнэ.

3.5.2. Шанаа хэсэгт массаж хийж, амны хөндийд цугларсан шүлсийг гоожуулж шүлсний саванд цуглуулна.

3.5.3. Шүлс цуглуулах савны 1/3 хэсэг хүртэл (шүлсний хөөсийг тооцохгүйгээр) шүлсийг цуглуулна.

3.5.4. Шүлс цуглуулж дууссаны дараа шүлс цуглуулах савны тагийг сайтар таглана.

3.5.5. Савтай шүлсийг сорьц цуглуулах ажилтанд өгнө.

3.6. Эд, эсийн сорьц авах: Уушгины эдийн гүнээс буюу гуурсан хоолойноос 0.5 см талтай шоо хэлбэртэй огтолж аваад, ариун саванд эсхүл зориулалтын вирус тээвэрлэх уусмал бүхий хуруу шилэнд хийж сайн таглана.

Дөрөв. Сорьцыг хадгалах, зөөвөрлөх

4.1. Хамрын хөндийн арчдас, хамар-залгиурын арчдас, ам-залгиурын арчдас, мөгөөрсөн хоолойн сорьцыг 24-48 цагийн дотор мөсөн элемент бүхий саванд хийж, нэмэх 2-8°C-д тээвэрлэж, лабораторид хүргэнэ. 48 цагийн дотор тээвэрлэх боломжгүй бол хасах 70°C-д хадгалж хөлдүүгээр тээвэрлэж, лабораторид хүргүүлнэ.

4.2. Эд, эсийн сорьцыг нэмэх 2-8°C-д тээвэрлэж, лабораторид яаралтай хүргэнэ. Боломжгүй бол хасах 70°C хэмд хадгалж, хөлдүүгээр тээвэрлэнэ.

4.3. Сорьцыг тээвэрлэхийн өмнө илгээх лабораторид урьдчилан мэдэгдэнэ.

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕД ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ ХИЙХ ТҮР ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх үйл ажиллагаанд энэхүү түр зааврыг мөрдөнө.

1.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед урьдчилан сэргийлэх болон голомтын байнгын, эцсийн халдваргүйжүүлэлт хийнэ.

1.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын маршрутын дагуух халдваргүйжүүлэлт болон урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг хувь хүн, байгууллага, мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэх, эсвэл өөрийн хүсэлтээр болон гэрээ байгуулж тусгай зөвшөөрөл бүхий хувийн аж ахуйн нэгжээр хийж гүйцэтгүүлнэ.

1.4. Урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг цар тахлын үед байгууллага аж ахуйн нэгж зааврын дагуу тогтмол хийнэ.

1.5. Голомтын байнгын халдваргүйжүүлэлт нь өвчтөн байрлаж буй эмнэлгийн өрөөнд өдөр тутам хийгдэнэ.

1.6. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлын гэр орон, ажлын байр, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан болон тусгаарласан өрөө, тээвэрлэсэн машин, нас барсан тохиолдолд цогцос зөөсөн дамнуурга, өрөө, тавиур, хөргөгч зэрэг халдвар дамжих эрсдэлтэй хэсгүүдэд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг хийнэ.

Хоёр. Урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт

2.1. Орон сууц, нийтийн байр болон аж ахуйн нэгжүүд хүний гар хүрэх бүх гадаргууд байнгын цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийнэ.

2.2. Гудамж талбай болон нийтийн эзэмшлийн гадаад орчинд зөвхөн угаалга, цэвэрлэгээ хийнэ.

Гурав. Голомтын халдваргүйжүүлэлт

3.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтод халдваргүйжүүлэлт хийх үйл ажиллагааг Зоонозын өвчин судлалын үндэсний төв мэргэжил арга зүйн удирдлага, зохицуулалтаар ханган ажиллана.

3.2. Орон нутагт голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг ЗӨСТ, ЭМГ болон сургагдсан ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтийн тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага хийнэ.

3.3. Эрүүл мэндийн байгууллагаас өгсөн тархвар судлалын дүгнэлт, мэдээллийн (хамрах хүрээ, хаяг, байршил) дагуу холбогдох байгууллагын томилогдсон шуурхай хариу арга хэмжээний баг голомтын халдваргүйжүүлэлтийг халдварын нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулна.

3.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийг тухайн эмнэлгийн шуурхай хариу арга хэмжээний баг гүйцэтгэнэ.

3.5. Гадаад улс орноос иргэдийг татан авалт хийж буй тусгай үүргийн, цэргийн зориулалттай тусгай үүргийн болон дипломат шугамаар ирж буй онгоц, зорчигчдын ачаа тээшинд хийх эцсийн халдваргүйжүүлэлтийг Хилийн мэргэжлийн хяналтын алба зохион байгуулан ажиллана.

3.6. Хот хооронд нислэг үйлдэж буй дотоодын нислэг, ачааны нислэгээр буусан карго ачаа, шуудан, ачаа тээш буусан талбай, барилга байгууламжийн халдваргүйжүүлэлтийг Хилийн мэргэжлийн хяналтын албаны хяналтан дор тухайн тээвэр зуучийн байгууллага, авиа компани бүрэн хариуцаж, шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагаар гүйцэтгүүлнэ.

3.7. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон батлагдсан эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн өвчтөн нь гэрээр эмчлүүлэх тохиолдолд халдваргүйжүүлэлтийг эрүүл мэндийн байгууллагаас гаргасан заавар зөвлөмжийн дагуу өөрөө хийнэ.

3.8. Гэрийн нас баралт бүртгэгдсэн тохиолдолд харьяа сум, өрхийн эмнэлэг халдваргүйжүүлэлт хийнэ.

3.9. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын улмаас өвчтөн эмнэлэгт нас барсан тохиолдолд эмнэлгийн халдваргүйжүүлэлтийн баг халдваргүйжүүлэлтийг зааврын дагуу хийнэ.

3.10. Оршуулах үйл ажиллагааны явцад ашигласан тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлийн халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн хяналтан дор гэрээт байгууллага гүйцэтгэнэ.

Дөрөв. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтод эцсийн халдваргүйжүүлэлт хийх

4.1. Шуурхай хариу арга хэмжээний багийн үүрэг, үйл ажиллагааны дараалал:

4.1.1. Голомтод халдваргүйжүүлэлт хийх багийн бүрэлдэхүүнд тархвар судлагч, ариутгагч, жолооч нар байх багтах бөгөөд тархвар судлагч эмчийн хяналтад ажиллана.

4.1.2. Багийн гишүүд нь тархвар судлагч эмчийн хамт халдваргүйжүүлэлтэд шаардлагатай хамгаалах хувцас, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, сав суулга, эд аж ахуйн зүйлс, халдваргүйтгэлийн бодис зэргийг нарийвчлан тооцож, жагсаалтын дагуу бэлэн болгон дуудлагад авч явна.

4.1.3. Хавьтал, өвчтөн, цогцос зөөвөрлөсөн (нүүлгэн шилжүүлсэн) тээврийн хэрэгсэлд тухай бүр эцсийн халдваргүйжүүлэлтийг заавал хийнэ.

4.2.6. Голомтод эцсийн халдваргүйжүүлэлт хийх багийн гишүүд халдвар хамгааллын хувцас хэрэгслийг халдвараас сэргийлэх зааврын дагуу халдваргүй бүс буюу ногоон бүсэд өмсөнө.

4.1.4. Халдваргүйжүүлэлт хийж дууссаны дараа хэрэглэсэн хамгаалах хувцас хэрэгсэлийг зааврын дагуу шар бүсэд тайлна.

4.1.5. Өвчтөн байгаа өрөө тасалгаанд халдваргүйжүүлэлт хийхдээ гар хүрэх газар, гадаргуу болон тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний эд зүйлсийн гадаргууг арчиж, тааз хананы дээд хэсэг, их талбайг шүршиж, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний эд зүйлсийн гадаргууг арчиж халдваргүйжүүлнэ.

4.1.6. Голомтын халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд оролцсон багийн гишүүд хэрэглэсэн хамгаалах хувцас, цэвэрлэгээний материал, хог хаягдал зэргийг халдвартай хог, хаягдал цуглуулах шар уутанд хийж, савны гадна талыг халдваргүйжүүлэлтийн уусмалаар шүршин зөөвөрлөж, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 505 дугаар тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар"-ын дагуу устгана.

4.1.7. Голомтын халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд оролцсон багийн гишүүд коронавируст халдвар (КОВИД-19)-ын нууц үеийн хугацааг дуустал хугацаанд биеийн халууныг өдөрт 2 удаа хэмжиж биеийн байдалд ажиглалт хийнэ.

4.1.8. Хэрэв халуурах, ханиалгах, амьсгалахад хүндрэлтэй болох, гүйлгэх, үнэрлэх, амтлах мэдрэмж алдагдах зэрэг шинж тэмдэг илэрвэл байгууллагын эмч, тархвар судлагч болон захиргаанд мэдэгдэж оношийг яаралтай тодруулах, холбогдох арга хэмжээг авна.

4.1.9. Голомтод ажилласан илтгэх хуудсыг бичиж холбогдох газарт хүргүүлнэ.

4.2. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлтэд хэрэглэх багаж, хэрэгсэл

4.2.1. Хамгаалах хувцас хэрэгсэл (хамгаалах хувцас хэрэгсэлийг 1-2 ширхэг илүү авч явна)

4.2.2. Автомакс (мананцар үүсгэгч)

4.2.3. Уусмал найруулах сав

4.2.4. Хэмжээст сав

4.2.5. Хар, шар өнгийн хогийн уут, хог хийх тагтай сав

4.2.6. Нүдний шил халдваргүйжүүлэх спирт, сав

4.2.7. Халдваргүйжүүлэх уусмал

4.2.8. Гар халдваргүйжүүлэх бодис

4.3. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийхэд анхаарах зүйлс

4.3.1. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийхээс өмнө бүх хүмүүсийг өрөөнөөс гаргаж, цонх, хаалгыг хааж, цахилгаан хэрэгслийг тогноос салгана.

4.3.2. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийхээс өмнө дахин хэрэглэх аяга, таваг, гал тогооны хэрэгслийг уутанд хийж, 2%-ийн содын уусмалд хийх эсхүл 30 минут буцалгахыг зөвлөнө.

4.3.3. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийхээс өмнө задгай хоол хүнс болон өвчтөний хэрэглэж байсан хоолны үлдэгдлийг шүршиж, хог хаягдлыг шар өнгийн уутанд хийж Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/505 тоот тушаалын дагуу устгана.

4.3.4. Хөнжил, дэр, гудас зэрэг зөөлөн эдлэлийг хоёр талаас нь нэвт шүршиж 1 цагийн дараа гадаа дэлгэж хатаах эсхүл угааж хэрэглэхийг зөвлөнө.

4.3.5. Хөргөгчний гадна талыг шүршиж, дотор талыг 2%-ийн содын уусмалаар арчиж халдваргүйжүүлэн хаалгыг онгорхой орхино.

4.3.6. Агааржуулалтын хоолой руу шүрших аргаар халдваргүйжүүлнэ.

4.4. Өвчтөний явсан зам маршрутын дагуу халдваргүйжүүлэлт, хийх дараалал

4.4.1. Өвчтөнийг зөөвөрлөсөн машины зогсоол–байрнаас гарсан зам – байрны хаалганы бариул (гадна ба дотор тал)- хөл арчдаг дэвсгэр–үүдний танхимын агаарт жавелионы 0.06%-ийн уусмалыг 1м^2 талбайд 100 мл уусмал орохоор тооцож, шүршиж халдваргүйжүүлнэ.

4.4.2. Шат–шатны бариул– хажуу хана-лифтний хаалга, шал, лифтэн доторхи агаар – хана, тааз зэргийг шүршиж, товчлуурыг арчиж халдваргүйжүүлнэ.

4.4.3. Өвчтөн тусгаарлагдаж байсан давхарт гарч агаар – шал – хана – давхрын өрөөнүүдийн хаалга зэргийг коридорын эцэс хүртэл шүршиж халдваргүйжүүлсэний дараа өрөөний үүдэнд буцаж ирнэ.

4.4.4. Өрөөний хаалганы гадна тал, бариул, дотор талыг шүршиж халдваргүйжүүлсэний дараа хаалгыг нээж өрөөний агаарт нэг минутын турш мананцар үүсгэж шүршинэ.

4.5. Өрөөнд халдваргүйжүүлэлт хийх дараалал:

4.5.1. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг байрны гадна талын хаалганаас эхлэн гадна талаас дотогш дээрээс доош гэсэн чиглэлээр хийнэ.

4.5.2. Хаалганы гадна, дотор талын бариул – өрөөний агаар – хана, шал –цонх, цонхны тавцан–хөшиг–тавилгын гадна, дотор тал–хөнжил, дэвсгэр даавуу, гудасны бүх гадаргууг бүрэн шүршиж хогийн савны дотор гадна талыг шүршинэ

4.5.3. Телевизор, компьютер зэрэг цахилгаан хэрэгсэлийг тогноос бүрэн салгасаны дараа шүршиж, уусмалын манан буусны дараа халдваргүйжүүлэх уусмалтай алчуураар арчина.

4.5.4. Ор дэрний цагаан хэрэглэлийг зөөлөн хөдөлгөөнөөр сугалан авч жавелионы 0.06%-ийг уусмалд бүрэн живүүлж орхино.

4.5.5. Ванн-шүршүүр-угаалтуур–суултуурыг шүршиж, суултуурт гипохлорид кальци 200гр хийж тагийг таглаж орхино.

4.5.6. Халдваргүйжүүлэлт хийснээс хойш 1-2 цагийн дараа чийгтэй цэвэрлэгээ хийж, өрөөг агааржуулна.

Хүснэгт 1. Халдваргүйжүүлэх бодисын найрлага, хэрэглэх арга

№	Бодисын нэр	Ажлын уусмал	Бодисын хэмжээ	Уусмалын хувь	Хэрэглэх зориулалт
1	Клорсепт	5 л	1 ш	0,02%	Урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлөг болон галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгслэл, өрөө тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ сандал, тавиур, шүүгээ гэх мэт хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ.
		2 л	1 ш	0.05%	Урьдчилан сэргийлэх зорилгоор ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуур, шүршүүр, хана, шал, бусад хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ.

2	Жавелион	10 л	1 ш	0.015%	Урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлөг болон галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгслэл, өрөө тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ сандал, тавиур, шүүгээ гэх мэт хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ.
		10 л	2 ш	0.03%	Урьдчилан сэргийлэх зорилгоор ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуур, шүршүүр, хана, шал, бусад хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ.
		10	4 ш	0.06%	Голомтын эцсийн халдваргүйтгэлийн үед агаарын хөлөг болон галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгслэл, өрөө тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ сандал, тавиур, шүүгээгээ гэх мэт хатуу гадаргуу, бүх төрлийн зөөлөн эдлэлийг 1 цаг живүүлж халдваргүйжүүлнэ.
		10	7	0.1%	Голомтын эцсийн халдваргүйтгэлийн үед ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуур, шүршүүр, хана, шал, бусад хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ.
3	ДП-2Т	7.5	1	0.02%	Урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлөг болон галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгслэл, өрөө тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ сандал, тавиур, шүүгээ гэх мэт хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ.
		7.5	2	0.04%	Голомтын эцсийн халдваргүйтгэлийн үед агаарын хөлөг болон галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгслэл, өрөө тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ сандал, тавиур, шүүгээгээ гэх мэт хатуу гадаргуу, бүх төрлийн зөөлөн эдлэлийг 1 цаг живүүлж халдваргүйжүүлнэ.
		7.5	5	0.1%	Голомтын эцсийн халдваргүйтгэлийн үед ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуур, шүршүүр, хана, шал, бусад хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ.
4	Просан	5	1	0.2%	Урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлөг болон галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгслэл, өрөө тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ сандал, тавиур, шүүгээ гэх мэт хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ.
		5	2	0.4%	Голомтын эцсийн халдваргүйтгэлийн үед агаарын хөлөг болон галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгслэл, өрөө тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ сандал, тавиур, шүүгээгээ гэх мэт хатуу гадаргуу, бүх төрлийн зөөлөн эдлэлийг 30 минут живүүлж халдваргүйжүүлнэ.
		5	5	0.1%	Голомтын эцсийн халдваргүйтгэлийн үед ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуур, шүршүүр, хана, шал, бусад хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ.
5	40%-ийн гипс хлорид кальци /хуурай/	10	50 гр	0.2%	Шингэн хаягдал, нүхэн жорлон, бохир усны цооногийг халдваргүйжүүлнэ.
		10	125 гр	0.5%	Шингэн хаягдал, нүхэн жорлон, бохир усны цооногийг халдваргүйжүүлнэ.

6	Содын уусмал	1 л	20гр	2%	Бүх төрлийн хүүхдийн тоглоомыг халдваргүйжүүлнэ.
7	Гипохло-рид натри Белизна	9850 мл	150мл		Шал хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу
		9400 мл	600 мл	1%	Ариун цэврийн ерөөний угаалтуур, суултуур

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН БАТЛАГДСАН ТОХИОЛДЛЫН ТАРХВАР СУДАЛГААНЫ ХУУДАС

1. Ерөнхий мэдээлэл:	
Сэжигтэй Магадлалтай Батлагдсан	
Хэрэв батлагдсан бол: Анхдагч , Хоёрдогч , Давтан , Зөвөөрлөгдсөн	
Батлагдсан тохиолдлын дугаар	
Биеийн байдал	Маш хүнд , Хүнд , Хүндэвтэр , Дунд , Хөнгөн , зовиургүй
Мэдээлсэн огноо	___ он ___ сар ___ өдөр ___ цаг ___ минут
Судалгаа эхэлсэн огноо	___ он ___ сар ___ өдөр ___ цаг ___ минут
Судалгаа авсан хүний овог, нэр, ажлын газар, албан тушаал, утасны дугаар	
Асуумжинд хариулж буй хүний овог, нэр, өвчтөний хэн болох, гэрийн хаяг, утасны дугаар (өвчтөн маш хүнд, асуумжинд хариулах боломжгүй, нас барсан бол хамаарал бүхий иргэнээс асуумж авна)	
Тохиолдлыг илрүүлсэн байдал	идэвхтэй тандалтаар , өөрөө ирсэн , хилийн нэвтрэх цэгт , түргэн тусламжаар , өөр эмнэлгээс шилжиж ирсэн , бусад
Эмнэлэгт үзүүлсэн огноо	___ он ___ сар ___ өдөр ___ цаг ___ минут
Эмнэлэгт хэвтсэн эсэх	Тийм Үгүй Мэдэхгүй Тийм бол огноо: ___ он ___ сар ___ өдөр ___ Хэвтсэн эмнэлгийн нэр
Халдварын эх уурхай тогтоогдсон эсэх? Тийм Үгүй	
Хэрэв тийм бол эх уурхай болсон өвчтөний овог, нэр, нас , хүйс: эрэгтэй , эмэгтэй , гэрийн хаяг	
Хавьтал болсон газар: Өрх/Гэр Эмнэлэг/ЭМБ Ажлын газар Сургууль/цэцэрлэг Бусад (бичнэ үү)	
Хавьтал болсон сүүлийн огноо: ___ он ___ сар ___ өдөр	
Хавьтал болсон хугацаа: Урт (>1 хоногоор) , Дунд (цагаар) , Богино (минутаар)	
Өмнө Ковид-19 халдвараар өвдсөн эсэх: тийм үгүй Тийм бол огноо ___ он ___ сар ___ өдөр Дархлаажуулалтад хамрагдсан эсэх: тийм үгүй Вакцины нэр: Астразенекал , Вероцелл , Файзер , Спутник В , Бусад	
I тунд хамрагдсан огноо ___ он ___ сар ___ өдөр II тунд хамрагдсан огноо ___ он ___ сар ___ өдөр III тунд хамрагдсан огноо ___ он ___ сар ___ өдөр IV тунд хамрагдсан огноо ___ он ___ сар ___ өдөр	
2. Хүн ам зүйн мэдээлэл:	
Овог:	Нэр:
Нас (жил, сараар): жил сар	Хүйс: Эрэгтэй , Эмэгтэй
Регистрийн дугаар	Төрсөн огноо: ___ он ___ сар ___ өдөр
Утасны дугаарууд	
Иргэншил	
Гэрийн хаяг	
Хэрэв гадаадын иргэн бол байрлаж буй газар, хаяг	Байрлаж буй газрын нэр: Дэлгэрэнгүй хаяг:
Нийгмийн байдал	Албан хаагч , Ажилчин , Ажилгүй , Оюутан , Сурагч , Хувиараа , Тэтгэвэрт , Малчин , Цэцэрлэг , Гэрт , Бусад:

Ажлын газрын (ажил, сургууль, цэцэрлэг) нэр, дугаар	
Мэргэжил, албан тушаал	
Ам бүлийн тоо	__ __

3. Илэрсэн эмнэлзүйн шинж тэмдгүүд			Тийм бол илэрсэн огноо
Халуурах ($\geq 37.1^{\circ}\text{C}$)	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	Хэм $^{\circ}\text{C}$ __ он __ сар __ өдөр	
Хоолой хөндүүрлэх/өвдөх	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	__ он __ сар __ өдөр	
Хуурай ханиалгах	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	__ он __ сар __ өдөр	
Нусгайрах	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	__ он __ сар __ өдөр	
Хамар битүүрэх	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	__ он __ сар __ өдөр	
Үнэрлэх мэдрэхүй алдагдах	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	__ он __ сар __ өдөр	
Амтлах мэдрэхүй алдагдах	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	__ он __ сар __ өдөр	
Амьсгал давчдах	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	__ он __ сар __ өдөр	
Толгой өвдөх	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	__ он __ сар __ өдөр	
Булчингаар өвдөх	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	__ он __ сар __ өдөр	
Үе мөч өвдөх	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	__ он __ сар __ өдөр	
Ядрах, сульдах	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	__ он __ сар __ өдөр	
Бусад	Тийм __ Үгүй __ мэдэхгүй __ Тийм бол шинж тэмдгийг бичнэ ҮҮ.....	__ он __ сар __ өдөр	

4. Халдвартай байсан хугацаа: __ он __ сар __ өдрөөс __ он __ сар __ хүртэл
(Эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн бол илрэхээс өмнөх 2 хоног, илрээгүй бол сорьц авсан өдрөөс өмнөх 2 хоногоос эхлэн тооцно)

5. Архаг өвчин:		
Таргалалттай эсэх	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	
Хорт хавдраар өвчилсөн эсэх	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	
Чихрийн шижинтэй эсэх	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	
ХДХВ/ бусад дархлаа дарангуйлагдах өвчтэй эсэх	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	
Зүрх судасны эмгэг өвчтэй эсэх /АДИӨ гэх мэт/	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	
Багтраа өвчтэй эсэх	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	
Уушгины архаг өвчтэй эсэх /багтраанаас бусад/	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	
Элэгний архаг өвчтэй эсэх	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	
Цусны архаг өвчтэй эсэх	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	
Жирэмсэн / хэдэн сартай/	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	
Бөөрний архаг өвчтэй эсэх	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	
Мэдрэлийн архаг өвчин, эмгэгтэй эсэх	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	
Эрхтэн, чөмөг шилжүүлэн суулгуулсан эсэх	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	
Бусад хавсарсан өвчтэй эсэх	Тийм __ Үгүй __ Мэдэхгүй __	

5. Сүүлийн 10 хоногийн хугацаанд халдварт өртөх эрсдэл			
Халдварт өртсөн байж болох эрсдэл	Тийм бол хаана	Тийм бол хэзээ	Хугацаа (хоног)
Аялсан эсэх: Тийм __ Үгүй __			
Гадаад оронд амьдарч, сурч байгаад ирсэн эсэх: Тийм __ Үгүй __			
Олон нийтийн арга хэмжээнд оролцсон эсэх: Тийм __ Үгүй __			

Амьсгалын замын халдварын сэжигтэй хүнтэй хамт байсан эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>			
Ажил, сургууль, цэцэрлэгт явсан эсэх: Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>			
6.Эрүүл мэндийн байгууллагад шинж тэмдэг эхлэхээс өмнөх 10 хоногт хандсан эсэх: Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>, Хэрэв тийм бол:			
Хандсан шалтгаан	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Хэзээ (огноо)	Хэдэн удаа
Эмнэлэгт үзүүлсэн			
Шинжилгээ өгсөн			
Хэвтэн эмчлүүлсэн			
Өвчтөн асарсан			
Хүн үзүүлэхээр хамт явсан			
Тусгаарлагдсан эсэх	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Хэрэв тийм бол: Эмнэлгийн нэр: Тусгаарлагдсан огноо: _____ он ____ сар _____		

Хүндэрсэн байдал	
Эрчимт эмчилгээний тасаг (ЭЭТ)-т хэвтэж эмчлүүлсэн	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй Тийм бол _____ он ____ сар _____ өдөр _____ он ____ сар _____ өдөр
ЭЭТ-аас гарсан огноо	_____ он ____ сар _____ өдөр
Зохиомол амьсгал хийсэн	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй Тийм бол хугацаа (хоног) _____ Эхэлсэн _____ он ____ сар _____ өдөр Зогсоосон _____ он ____ сар _____ өдөр
Амьсгалын цочмог дистресс хамшинж	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй Эхэлсэн _____ он ____ сар _____ өдөр
Бөөрний цочмог дутмагшил	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй Эхэлсэн _____ он ____ сар _____ өдөр
Зүрхний дутмагшил	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй Эхэлсэн _____ он ____ сар _____ өдөр
Цус бүлэгнэлтийн алдагдал	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй Эхэлсэн _____ он ____ сар _____ өдөр
Рентген шинжилгээнд уушгины хатгалгаатай	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй Тийм бол _____ он ____ сар _____ өдөр
Бусад хүндрэлүүд	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй Тийм бол бичих _____
ЕСМО (хүчилтөрөгчжүүлэх аппарат) эмчилгээнд орсон	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй
Судас агшааж даралт бууруулах эмчилгээнд орсон	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй

7.Вирус судлалын шинжилгээний дүн						
Сорьцын нэр	Давтамж	Сорьц авсан огноо	Лабораторийн нэр	Шинжилгээний төрөл	Шинжилгээний хариу	Хариу гарсан огноо
Хамар залгиурын арчдас	Сорьц 1					
	Сорьц 2					
	Сорьц 3					
	Сорьц 4					
Ам залгиурын арчдас	Сорьц 1					
	Сорьц 2					
Бусад (бичих)						

8.Тавилан: Эдгэрсэн <input type="checkbox"/> , Сайжирсан <input type="checkbox"/> , Нян тээгч <input type="checkbox"/> , Нас барсан <input type="checkbox"/>
Эдгэрсэн бол эмнэлгээс гарсан огноо: _____ он ____ сар _____ өдөр
Нас барсан бол огноо: _____ он ____ сар _____ өдөр

Задлан шинжилгээ хийсэн бол огноо: _____ он ____ сар _____ өдөр
 Задлан шинжилгээ хийсэн шалтгаан:

Задлан шинжилгээний дүгнэлт:

9. Батлагдсан тохиолдлын хавьтлын талаарх товч мэдээлэл:
 Эрсдэл өндөртэй болон эрсдэл багатай хавьтал болсон нийт хүний тоо |__|__|, үүнээс гэртээ |__|__|, бусад газарт |__|__|,
 Хавьтлаас КОВИД-19 халдвараар өвчилсөн нийт хүний тоо |__|__|

10. Эцсийн онош

11. Эцсийн дүгнэлт: Сэжигтэй |__|, Магадлалтай |__|, Батлагдсан |__|, Онош үгүйсгэгдсэн |__|
 Батлагдсан бол: тархвар судалгаагаар |__|, эмнэл зүйгээр |__|, лабораториор |__|
 Хэрэв онош үгүйсгэгдсэн бол оношийг бичих

Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар эсэх: Тийм |__| Үгүй |__|
 Эцсийн дүгнэлт гаргасан тархвар судлаачийн овог, нэр

Албан тушаал, утасны дугаар |__|__|__|__|__|__|

Анхааруулга: Батлагдсан тохиолдлын голомтонд авч хэрэгжүүлсэн шуурхай хариу арга хэмжээ, хавьтлуудын талаарх мэдээллийг уг судалгааны хуудсанд хавсаргана.

12. Хавьтлын мэдээлэл

№	Овог, нэр	Нас / хүйс	Регистрийн дугаар	Утасны дугаар	Таны юу болох?	Хавьтал болсон эхний огноо	Хавьтал болсон сүүлийн огноо	Тусгаарласан	
								Газар	Огноо

					Үгүй _			Үгүй _	
	Орой	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	
3	Өглөө	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	
	Орой	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	
4	Өглөө	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	
	Орой	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	
5	Өглөө	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	
	Орой	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	Тийм _ Үгүй _	

2. Хавьтлыг шинжилгээнд хамруулсан байдал

Шинжилгээний давтамж	Хамрагдсан огноо	Авсан сорьцын төрөл	Хийгдсэн шинжилгээ	Шинжилгээний хариу
Эхний шинжилгээ	_____он _____ сар _____ өдөр _____цэг _____ минут	<ul style="list-style-type: none"> Хамар залгиурын арчдас _ Ам залгиурын арчдас _ Бусад 	<ul style="list-style-type: none"> Түргэвчилсэн антиген тест _ бх-ПГУ-ын шинжилгээ _ 	<ul style="list-style-type: none"> Сөрөг _ Зэрэг _
Давтан шинжилгээ (шинж тэмдэг илэрсэн болон эмчийн заалтаар)	_____он _____ сар _____ өдөр _____цэг _____ минут	<ul style="list-style-type: none"> Хамар залгиурын арчдас _ Ам залгиурын арчдас _ Бусад 	<ul style="list-style-type: none"> Түргэвчилсэн антиген тест _ бх-ПГУ-ын шинжилгээ _ 	<ul style="list-style-type: none"> Сөрөг _ Зэрэг _